



مجلس شورای اسلامی و مدرسین  
مجلس خبرگان رهبری  
مجلس خبرگان  
مجلس خبرگان

# АГУУЛГА

---

ӨМНӨХ ҮГ

2021 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ

<b>01</b>	УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА	9
<b>02</b>	УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА	25
<b>03</b>	УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА	51
<b>04</b>	УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА	59
<b>05</b>	ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ	73
<b>06</b>	УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА	89
<b>07</b>	ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА	103
	НЭГДСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, 2022 ОНЫ ЗОРИЛТ	119



## ӨМНӨХ ҮГ

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны тайланг эмхэтгэн Та бүхэнд өргөн барьж байна.

Өнгөрөгч онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх эрх зүйн шинэтгэл эрчимжиж, Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилтийг дэмжих дэд бүтэц сайжирч, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа дээшлэн, “Парламентын боловсрол” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн онцлог жил байлаа.

Коронавируст (КОВИД-19) цар тахлын онцгой нөхцөл үргэлжилсэн цаг үед парламентын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангах хуульд заасан чиг үүргээ бид үр дүнтэй хэрэгжүүлж чадсан.

Үүний үр дүнд өмнөх онтой харьцуулахад Улсын Их Хурлаас баталсан хуулийн шинэчилсэн найруулга 62.5 хувь, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 110.2 хувь, нийт баталсан хууль 72.2 хувиар өссөн байна.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хүрээнд 2021 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн батлуулахад мэргэжил, арга зүйн туслалцааг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж ажиллалаа.

Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмыг Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн хүрээнд хууль тогтоомж боловсруулах, батлуулах, ёсчлох, холбогдох байгууллагад хүргүүлэх, чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэх зэрэг 19 дүрэм, журмыг шинэчлэн баталлаа.

Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагаанд цахим шилжилт хийх дэд бүтэц бүрдүүлэхэд чиглэсэн цогц шинэчлэлийг хийж чадлаа.

“Парламентын боловсрол”, “Өсвөрийн парламент” шинэ хөтөлбөрийг эхлүүлж, Парламентын судалгааны хүрээлэнгийн “rrch.parliament.mn”, Парламентын боловсролын “edu.parliament.mn”, Парламентын сургалтын “training.parliament.mn” дэд цахим хуудсуудыг нээж, парламентын боловсролыг цахим технологи ашиглан олон нийтэд хүргэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах шинэ боломжийг бүрдүүлэв.

Ингэснээр Үндсэн хуульт ёс, парламентын ардчилал, эрх зүйт төр, хүний эрх, засаглалын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэгийг иргэд, өсвөр үеийнхэнд түгээх цахим технологид суурилсан шинэ механизм бүрдэж байна.

“Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн

баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан нь албан хаагчдын хувь хүний болон гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх бодлогод чухал алхам боллоо.

Бид 2022 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлж эрх зүйн шинэтгэл хийх, хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх, парламентын хянан шалгах чиг үүргийг шинэ шатанд гаргах замаар парламентын тогтолцоог бэхжүүлэх, цахим шилжилт хийж, ард түмний засаглах эрхийг хангах Улсын Их Хурлын стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын зөвлөгөө, туслалцааг мэргэшлийн өндөр түвшинд үзүүлж, **МЭРГЭШСЭН, БҮТЭЭЛЧ, ХАРИУЦЛАГАТАЙ** ажлын алба болж төлөвших эрхэм зорилтоо амжилттай хэрэгжүүлж, ажиллах болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Лувсандоржийн ӨЛЗИЙСАЙХАН

# 2021 ОНЫ

## ОНЦЛОХ 10

# ҮЙЛ ЯВДАЛ



1. 2019 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийг боловсруулан батлуулах ажлыг эрчимжүүлэв.

Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарьт тусгагдсан 31 хуулиас 7 хуулийг (батлагдсан 4 багц хуульд 3 хуулийн агуулга тусгагдсан) Улсын Их Хурлаас боловсруулж, хэлэлцэн баталсан байна.



2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг хэлэлцэн батлахад “хуулийн төслийн мэдээлэл, лавлагааны иж бүрдэл”-ээр хангав.

Хуулийн төслийг боловсруулах, Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахад мэргэшлийн өндөр түвшинд боловсруулсан, шинжлэх ухааны үндэслэл бүхий “хуулийн төслийн мэдээлэл, лавлагааны иж бүрдэл”-ээр хангаснаар Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх шинэлэг хэлбэр, жишиг тогтоов.



### **3. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын 171 удаагийн хуралдааныг цахим аар зохион байгуулав.**

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу чуулганы нэгдсэн хуралдааныг цахим хэлбэрээр болон 5 танхимд нэгэн зэрэг хуралдуулах бэлтгэлийг хангаж, нарийвчилсан төлөвлөгөө гарган, нэгжийн ажлын уялдааг ханган ажилласнаар чуулганы нэгдсэн 42, Байнгын хороодын 110, дэд хороодын 8, түр хороодын 11 удаагийн буюу нийт хуралдааны 50.6 хувийг цахим хэлбэрээр зохион байгууллаа.



### **4. Түүхт ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг зохион байгуулав.**

Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэнэ, монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэв.



### **7. “Парламентын боловсрол” хөтөлбөрийг эхлүүлж, “Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг зохион байгуулав.**

“Парламентын боловсрол” хөтөлбөрийн гарын авлагыг 12-14, 15-17 насны ангиллаар боловсруулан, хэрэглээнд нэвтрүүлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар өсвөр үеийнхэнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаар зөв ойлголт өгч, шийдвэр гаргах түвшинд тэдний оролцоог бодитой дэмжих зорилго бүхий “Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг анх удаа зохион байгуулав.



### **8. Парламентын сургалтын 15 дэд хөтөлбөр боловсруулж, сургалтын цахим систем бүтээв.**

Парламентын сургалтын цогц хөтөлбөрийн хүрээнд Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 15 дэд хөтөлбөр боловсруулж, парламентын мэргэшсэн ажлын албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт агуулга, сонгон суралцах боломжийг бүрдүүлсэн “Сургалтын цахим систем”-ийг нэвтрүүллээ.



**5. Тамгын газрын үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмаас 19-ийг шинэчлэв.**

Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 95 дүрэм журмаас 19-ийг нь шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах хуульд заасан чиг үүргээ бүтээмжтэй, үр нөлөөтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх эрх зүйн шинэ соёл, орчин бүрдлээ.



**6. Тамгын газрын цахим сүлжээний техник тоног төхөөрөмжийг шинэчилж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.**

Улсын Их Хурлын дотоод цахим серверийн техникийн үзүүлэлтийг нэмэгдүүлж, серверийн өрөөг шинэчлэн засварлаж, ашиглагдаж буй системүүдийг төрөлжүүлэн оновчтой зохион байгуулснаар төхөөрөмжийн ашиглалт эрс сайжирч, интернэтийн нөөц урсгалтай болсноор байгууллагын интернэтийн үйлчилгээ тасалдалгүй хэвийн явагдах нөхцөл бүрдэв.



**9. “Улсын Их Хурлын Тамгын газар” брэндбүүктэй болов.**

Тамгын газрын өвөрмөц онцлог, соёлыг илэрхийлсэн брэндбүүк бүтээж, байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх, таниулан сурталчлах, үнэт зүйлээ өвлөн хэвшүүлэх шинэ өнгө төрх, хэв маягийг бий болгов.



**10. Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг угтсан 30 зорилт дэвшүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллав.**

Түүхэн ойг угтаж Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагааны бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэх, хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх, цахим парламент, парламентын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, ёс зүй, сахилга, хариуцлагатай парламентын ажлын албыг төлөвшүүлэх чиглэлээр “Гучин зорилт” дэвшүүлж, хэрэгжүүлэв.





# УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 1.1. Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлсэн зөвлөгөө, тусалцаа
- 1.2. Хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр үзүүлсэн тусалцаа
- 1.3. Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр үзүүлсэн зөвлөгөө, тусалцаа
- 1.4. Дүгнэлт, зорилт

■ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг баталж, Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэв.

## I БҮЛЭГ

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

### 1.1. Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлсэн зөвлөгөө, тусалцаа

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 72 удаа 324 цаг 34 минут, Байнгын, дэд, түр хороодын хуралдаан 266 удаа (үүнээс Байнгын хороод 231, дэд хороод 14, түр хороод 21 удаа) 409 цаг 19 минут хуралдаж, 913 (давхардсан тоогоор) хууль, тогтоолын төсөл, 59 тайлан, илтгэл, мэдээлэл, хяналт шалгалтын дүн хэлэлцсэн байна.

Байнгын болон дэд, түр хорооны 112 тогтоол батлуулан, олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц зөвшилцөх 10, хэлэлцэх эсэх 73, анхны хэлэлцүүлгийн 104, зөвшилцөх 6, соёрхон батлах 9, холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн 38, бусад асуудлаар 72 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн 64 танилцуулга,

анхны хэлэлцүүлгийн 2107 (үүнээс дэмжигдсэн 2056, дэмжигдээгүй 51), эцсийн хэлэлцүүлгийн 98 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж, шийдвэрлүүлээ.

Тамгын газар 415 хууль, 106 тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн, Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, анхдагч хууль 26, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 7, хуулийн шинэчилсэн найруулга 13, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 351, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 18, Улсын Их Хурлын тогтоол 106-г тус тус батлуулжээ.



Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан

Өмнөх онтой харьцуулахад хуулийн шинэчилсэн найруулга 62.5 хувь, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 110.2 хувь, нийт баталсан хууль 72.2 хувиар өссөн дүнтэй байгаа нь Тамгын газар парламентын хууль тогтоох

үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, техник зохион байгуулалтаар хангах хуульд заасан чиг үүргээ үрдүнтэй, бүтээмжтэй хэрэгжүүлэн ажилласныг илтгэх нэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

**72** 


НЭГДСЭН ХУРАЛДААН

**266** 


БАЙНГЫН, ДЭД, ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

**913** 

ХУУЛЬ, ТОГТООЛЫН ТӨСӨЛ



324 ЦАГ 34 МИНУТ




409 ЦАГ 19 МИНУТ

**59** 

ТАЙЛАН, ИЛТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ДҮН

**БАТАЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ:**



42   
 → 17

Тамгын газар Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтээр 42 удаа хууль, тогтоолын төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, Үндсэн хуулийн цэцэд гаргах Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарын 17 төслийг боловсруулан албажуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

218   
 → 101

Хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 122 хууль, тогтоол (үүнээс 95 хууль, 27 тогтоол)-ын бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хянаж, 73 хууль, тогтоол (үүнээс 59 хууль, 14 тогтоол)-ын төслийн хуульд заасан шаардлагыг хангуулав.

Улсын Их Хурлын даргын 2013 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 169 дүгээр захирамжаар баталсан “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга бэлтгэх, хянах журам”-ын дагуу Улсын Их Хурлаас баталсан 218 хууль, Улсын Их Хурлын 101 тогтоолын эцсийн найруулгыг хянаж, нэр томьёо, үг хэллэгийг жигдлэн, найруулгын болон дэс дараалал, бүтцийн зэрэг хууль зүйн техникийн шинжтэй засварыг хийж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах ажлыг зохион байгууллаа.

220   
 → 99

2021 онд анхдагч болон шинэчлэн найруулсан 30 хууль, Олон улсын гэрээ соёрхон батлах тухай 7 хууль, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 170 хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай 13 хууль, нийт 220 хууль, Улсын Их Хурлын 99 тогтоолыг хууль тогтоомжийн санд бүртгэн, баяжилт хийж, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хяналтын эх хувьд (цаасан) байршуулж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас [www.parliament.mn](http://www.parliament.mn), дотоод сүлжээ болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) цахим хуудаст байршуулсан.

  
 1300

Улсын Их Хурлын албан ёсны [www.parliament.mn](http://www.parliament.mn) цахим хуудас болон дотоод сүлжээнд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов 35, хууль, тогтоолын төсөл 233, олон улсын гэрээ, хэлэлцээрийн зөвшилцөх төсөл 13, холбогдох байгууллагын тайлан 22, санал, дүгнэлт, танилцуулга 344, мэдээ мэдээлэл 317, чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл 71, Байнгын, дэд, түр, хорооны хуралдааны тэмдэглэл 264, Улсын Их Хурлын гишүүдийн ирцийн мэдээ нэгийг тус тус байршуулав.

350  
  
 245

Улсын Их Хурлын Тамгын газрын хууль тогтоомжийн санд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 73 зарлиг, Ерөнхий сайдын 3 захирамж, Засгийн газрын 265 тогтоол, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 7 дүгнэлт, 2 тогтоолыг нэмж оруулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүд, байгууллага, иргэд, Улсын Их Хурлын Тамгын газрын болон Улсын Их Хурал дахь намын бүлгийн ажилтнуудыг 245 удаа лавлагаа, мэдээллээр хангав.

16138  
  
 8443

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 324 цаг 34 минутын явцын талаар 1229 хуудас товч болон 5375 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэл, 9534 хуудас хавсралт баримт бичгийн хамт нийт 16138 хуудас, Байнгын, дэд, түр хороодын хуралдааны 409 цаг 19 минутын явцын талаарх 1581 хуудас товч болон 6862 хуудас дэлгэрэнгүй тэмдэглэлийг дууны бичлэгээс буулган, хянан нийлж, хэвлэн, нийт 8443 хуудас баримт материалыг бүрдүүлэв.

**Чуулганы нэгдсэн хуралдаан**



324 ЦАГ 34 МИНУТ

5375 

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

9534 

ХАВСРАЛТ БАРИМТ БИЧИГ



409 ЦАГ 19 МИНУТ

1581 

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

6862 

ДЭЛГЭРЭНГҮЙ  
 ТЭМДЭГЛЭЛ

## Хууль тогтоомжид нийцүүлэн дүрэм, журмыг шинэчлэв.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Хууль зүйн дүгнэлт гаргах журам”-ыг баталсантай холбогдуулан Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан хууль зүйн дүгнэлт гаргахтай холбоотой 4 журмыг хүчингүй болсонд тооцсон бөгөөд хууль тогтоомж боловсруулах, хянах, батлуулах, ёсчлох,

хүргүүлэх ажиллагаатай холбоотой Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 5 журам, загварыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулав.

Шинэчлэн батлуулсан журам, загвар		Хүчингүй болсонд тооцсон журам	
<b>2021.09.28</b> <b>№624</b>	Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх журам	<b>2010.03.16</b> <b>№126</b>	Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар экспертийн дүгнэлт гаргах түр журам
<b>2021.09.28</b> <b>№625</b>	Хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэх журам	<b>2010.10.07</b> <b>№457</b>	Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар зөвлөхийн дүгнэлт гаргах журам
<b>2021.09.29</b> <b>№634</b>	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээх, бусад байгууллагад хүргүүлэх журам	<b>2016.11.03</b> <b>№795</b>	Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргах журам /загварын маягт/
<b>2021.09.29</b> <b>№636</b>	Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тусгах тэмдэглэгээ, Зарчмын зөрүүтэй саналын томъёоллын бичилтийн загвар, Хуульд оруулах өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгах томъёоллын загвар	<b>2017.01.17</b> <b>№43</b>	Хууль тогтоомжийн төсөлд эрх зүйн дүгнэлт гаргах журам
<b>2021.10.07</b> <b>№670</b>	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах журам		

“ ” **Дээрх журмууд шинэчлэн батлагдсанаар Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд арга зүй, зохион байгуулалтын зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий Улсын Их Хурлын Тамгын газрын нэгжүүдийн үйл ажиллагаа тодорхой болж, хууль тогтоомжийн чанар сайжрах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.**

## Хууль зүйн дүгнэлт гаргах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль зүйн дүгнэлт гаргах журам”-ын дагуу хууль тогтоомжийн төслийн талаарх хууль зүйн дүгнэлт 1, лавлагаа 1, зөвлөмж 1-ийг гаргаж, холбогдох Байнгын хороонд

хүргүүлж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлээ. Ингэснээр хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх, хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байх зарчмыг хангах, Улсын Их Хурлын хууль тогтоох ажлын чанар сайжрахад дэмжлэг болов.

## Хууль зүйн дүгнэлт, зөвлөмж, лавлагаа гаргасан эрх зүйн баримт бичиг



“Коронавируст халдварын цар тахлаас үүдэлтэй амьдралын доройтол, нийгэм, эдийн засгийн бэрхшээлийг даван туулах онцгой арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл



КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл



Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан “Хүсэлтээс бүхэлд нь татгалзах тухай” асуудлыг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар тогтоол

“**Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх зорилгоор хуулийн төсөл хүний эрхийг хангасан эсэхэд үнэлгээ хийх аргачлалыг боловсруулав.**



Гарын авлага

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан даргалагчид зориулсан хуулийн төсөл хэлэлцэн батлах үе шатыг хялбаршуулсан байдлаар тайлбарласан гарын авлагыг боловсруулж, “Хэлэлцэх асуудлын бүрдлийн хавтас”-ыг хэрэглээнд нэвтрүүлэв.

“**Хуралдаан даргалагч тус гарын авлага, хэлэлцэх асуудлын бүрдлийн хавтсыг ашигласнаар хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шат болон хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох шаардлагатай мэдээлэлтэй цогц байдлаар танилцан, хуралдааныг хуульд заасан журмын дагуу удирдан явуулахад дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.**

## 1.2. Хуралдааны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр үзүүлсэн туслалцаа


Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж, хуралдааны тэмдэглэлийг цаг тухайд нь гаргаж, албажуулан ажиллав. Улсын Их Хурлын чуулганы 72 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 231, дэд хороодын 14, түр хороодын 21 удаагийн хуралдааны бэлтгэлийг хангаж

хуралдууллаа. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу чуулганы нэгдсэн хуралдааныг 42 удаа, Байнгын хороодын хуралдааныг 110 удаа, дэд хороодын хуралдааныг 8 удаа, түр хороодын хуралдааныг 11 удаа цахимаар зохион байгууллаа.

### Чуулганы нэгдсэн 72 хуралдаан



### Байнгын, дэд, түр хороодын 266 хуралдаан



### Байнгын хороодын хуралдаан:



2020 оны намрын ээлжит чуулган (2021.01.02 - 2021.01.29)

2021 оны хаврын ээлжит чуулган (2021.03.15-2021.07.08)

2021 оны 9 дүгээр сар

2021 оны намрын ээлжит чуулган (2021.10.01-2021.12.30)



### Дэд хороодын хуралдаан:



### Түр хороодын хуралдаан:

№	Түр хороодын нэр	Хуралдааны тоо
1	Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо	7
2	Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хороо	2
3	"Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороо	12
<b>Нийт</b>		<b>21</b>

Улсын онцгой комиссоос өгсөн зөвлөмжийн дагуу хуралдаанд биечлэн оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүд болон холбогдох албан тушаалтнуудыг амны хаалт, хамгаалалтын нэг удаагийн бээлий, халдваргүйжүүлэгчээр хангаж, хуралдааны танхимын чийгшлийг 40 хувиас доошгүй, агаарын хэмийг цельсийн градусын 19-22-ын хооронд байлгах, агааржуулагч, кварцын аппарат ажиллуулах, цэвэрлэгээ,

халдваргүйжүүлэлт хийх ажлыг тухай бүр гүйцэтгэв. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааны ирцийг бүрдүүлэх, Улсын Их Хурлын гишүүдэд мэдээ, мэдээлэл, холбогдох зарыг шуурхай хүргэх үүднээс Мобиком корпорацийн smsnumber.mn үйлчилгээг ашиглан Улсын Их Хурлын гишүүд, холбогдох албан тушаалтнуудад 9491 удаа мэдээ, мэдээлэл, цахим урилгыг мессежээр шуурхай хүргэж ажиллалаа.

“ “ **Өмнөх онтой харьцуулахад Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тоо 18 хувь, Байнгын, дэд, түр хороодын хуралдааны тоо 17.7 хувь, цахимаар зохион байгуулсан чуулганы нэгдсэн хуралдааны тоо 2 дахин, Байнгын, дэд, түр хороодын хуралдааны тоо 3 дахин өссөн дүнтэй байна.**

Тиймээс ч чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг цахимаар зохион байгуулах ажиллагаа хэвшиж, парламентын хэвийн, тасралтгүй ажиллагааг бүрэн хангаж, Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах,

төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх Тамгын газрын хуульд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэж байна.

### **Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан зохион байгуулав.**

Улсын Их Хурлын даргын захирамжаар Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 110 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдөр зохион байгууллаа.

Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн

Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Засгийн газрын гишүүд болон Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлагууд оролцов.

Мөн гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчдийн байгууллагуудын тэргүүн нар, НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын байгууллагуудын төлөөллүүд цахимаар оролцсон юм.



*Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 110 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан*

### 1.3. Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр үзүүлсэн зөвлөгөө, туслалцаа

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор уг нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсны дагуу Улсын Их Хурлаар холбогдох хуулийг хэлэлцэн батлах зохион байгуулалтын бэлтгэл хангах, Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөл санаачлан боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа

үзүүлэх, судалгаа шинжилгээгээр хангахад анхаарч ажиллав.

Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолд 31 хуулийг хэлэлцэн батлахаар зааснаас анхдагч хууль 4, шинэчилсэн найруулгаар батлах хууль 19, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 8 тусгагдсан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар анхдагч 2 хууль, шинэчилсэн найруулга 10, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2 хууль тус тус батлагдсан байна.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлуулах хуваарьт заасан хууль тогтоомжийн 45 хувийг Улсын Их Хурлаас батлаад байна.

#### Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлуулах хууль тогтоомжийн судалгаа

##### БАТЛУУЛАХ ХУУЛЬ

31 

- Анхдагч хууль 4
- Шинэчилсэн найруулга 19
- Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 8

##### БАТЛАГДСАН ХУУЛЬ

14 

- Анхдагч хууль 2
- Шинэчилсэн найруулга 10
- Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2

Тамгын газар дээр дурдсан 14 хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулахад мэргэжил, арга зүйн туслалцааг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн


төслийг боловсруулахад Парламентын судалгааны хүрээлэнгээс хийсэн холбогдох судалгааны үр дүн, гадаад улс орнуудын парламентын хяналт шалгалтын жишгийг үндэслэн, өөрийн орны онцлогийг харгалзсан болно.

“2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулсан парламентын хянан шалгах үндсэн чиг үүргийг сонгодог парламентын жишигт нийцүүлэх зорилготой Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулав.




Хуулийн ажлын хэсэг

## Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн онцлог зохицуулалт



“ “ Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтын 21, 22, 23, 24 дүгээрт бичигдсэн Шүүхийн захиргааны тухай хууль (шинэчилсэн найруулга), Шүүхийн сахилгын хорооны тухай хууль (анхдагч хууль), Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын агуулгыг нэгтгэн тусгасан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулж, шүүхийн шинэтгэлийг үргэлжлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэв.

## Монгол Улсын Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн онцлог зохицуулалт



Түүнчлэн Төрийн байгуулалтын байнгын хорооны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 8/2512 тоот албан бичгээр Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар Засгийн

газарт чиглэл өгсөнтэй холбогдуулан уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажилд зохион байгуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



“ “ Батлагдсан дээрх хуулиудаас гадна Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллалаа.

## 1.4. Дүгнэлт, зорилт

### Дүгнэлт

2021 онд Тамгын газар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, төслийн бүрдүүлбэрийг хангах, хэлэлцүүлэн батлуулах бүх үе шатанд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг зохион байгуулах техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй,

бүтээмжтэй хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэж байна.


Үүнийг илтгэх нэг үзүүлэлт бол өмнөх онтой харьцуулахад парламентаас баталсан хууль тогтоомж 72,2 хувь, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 18 хувь, Байнгын, дэд, түр хороодын хуралдаан 17.7 хувиар тус тус өссөн дүн юм.

# 415



ХУУЛЬ



ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ӨСӨЛТ



# 106



ТОГТООЛ



Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль тогтоомжийг боловсруулан батлуулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ыг Улсын Их Хурлаас боловсруулах, хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Улсын Их Хурлаас 2021 оны байдлаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлуулах хуваарьт заасан хууль тогтоомжийн 45 хувийг батлаад байна.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан Хууль зүйн дүгнэлт гаргах журмыг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийн төслийн талаарх хууль зүйн дүгнэлт, лавлагаа, зөвлөмж тус бүр 1-ийг боловсруулж, холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх, хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байх зарчмыг хангах, Улсын Их Хурлын хууль тогтоох ажлын чанар сайжрахад бодит дэмжлэг болов.

Албан хаагчдыг коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтад хамруулах арга хэмжээг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэв.

Зохион байгуулалтын бэлтгэлийг өндөр түвшинд хангасны үндсэн дээр Ардын хувьсгалын 100 жилийн ой болон Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 110 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг цахимаар болон танхимаар нэгэн зэрэг зохион байгуулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэнэ, Монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан даргалагчид зориулсан хуулийн төсөл хэлэлцэн батлах үе шатыг хялбаршуулсан байдлаар тайлбарласан

гарын авлага боловсруулж, “Хэлэлцэх асуудлын бүрдлийн хавтас”-ыг хэрэглэж хэвшүүлснээр хуралдааныг хуульд заасан журмын дагуу саатал, зөрчилгүй удирдан явуулах боломжийг бүрдүүлээ.

2022 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүн шинжилгээ хийх ажлыг өргөжүүлж, Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоход арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг сайжруулахаар төлөвлөж байна.

### 2022 оны зорилт

#### ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ.

1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүн шинжилгээ хийх ажлыг өргөжүүлж, хуулийн төсөл хэлэлцүүлэх цахим системийн хэрэглээг шинэ шатанд гаргана.
  - 1.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд олон улсын жишиг аргачлалаар “Хууль зүйн дүгнэлт гаргах” ажлыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, хэвшүүлнэ.
  - 1.2. Хуулийн төсөл хэлэлцүүлэх болон иргэдийн санал, хүсэлт авах цахим системийн ашиглалт, хэрэглээг хэвшүүлж, хууль тогтоох үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог идэвхжүүлнэ.
2. Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэхэд арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.
  - 2.1. Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлж, хуулийн төсөл хүний эрхийг хангасан эсэхэд үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ.
  - 2.2. Хууль тогтоомжийн төсөл жендэрийн мэдрэмжтэй эсэхийг шалгуураар үнэлэх үнэлгээний аргачлалыг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.
3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлж, хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг сайжруулна.
  - 3.1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.
  - 3.2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг орчин үеийн парламентын жишигт нийцүүлж шинэчилнэ.





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 2.1. Хяналт шалгалт, үнэлгээний чиглэлээр үзүүлсэн туслалцаа
- 2.2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
- 2.3. Төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр үзүүлсэн зөвлөгөө, туслалцаа
- 2.4. Дүгнэлт, зорилт



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

## II БҮЛЭГ

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

### 2.1. Хяналт шалгалт, үнэлгээний чиглэлээр үзүүлсэн тусалцаа



Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг тогтоохдоо “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхтэй” гэж заасан.

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог..” байгуулах замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон.

Үндсэн хуульд оруулсан дээрх нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн хууль тогтоомжийн биелэлтийг хангах, Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөө, хянан шалгах чиг үүргийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын Их

Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Тамгын газрын зүгээс Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ажлын хэсгийн ахлагчаас өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай судалгаа, мэдээллийг боловсруулж, нийт 11 удаагийн (багц) мэдээллийг бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлж ажиллалаа.

Уг хууль батлагдсанаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодитой, үр нөлөөтэй хянах, төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангаж, Улсын Их Хуралд итгэх ард түмний итгэлийг нэмэгдүүлэх, хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тогтолцоо, механизмыг уялдуулан системчлэх, сайжруулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар, Парламентын судалгааны хүрээлэн хамтран Тамгын газрын хяналт шалгалтын нэгжийн чиг үүрэг, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хяналт шалгалтын чадавхыг сайжруулах зорилго бүхий уулзалт хэлэлцүүлгийг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав.

2022 онд хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, Тамгын газрын албан хаагчдыг чадавхжуулах, холбогдох журам, аргачлалыг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах замаар парламентын хянан шалгах үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.



*Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан*

Мөн “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах журам” болон холбогдох бусад журмыг шинээр болон шинэчлэн батлуулж, хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Улсын Их Хурлаас улсын төсөвт тавих хяналтыг үр дүнтэй явуулах, Улсын Их Хурлын гишүүдийг судалгаанд үндэслэсэн

бодитой мэдээллээр ханган ажиллахад зардал, үр нөлөөний тооцоолол хийх, зардал бууруулах санал боловсруулах чадавхыг дээшлүүлэх, богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлт, төсвийн төсөлд шинжилгээ хийх аргачлалуудыг батлуулах зорилтыг тавин ажиллаж байна.



*Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалтын чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий уулзалт, хэлэлцүүлэг*

## Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой арга хэмжээний төлөвлөгөө



Улсын Их Хурлын 2022 оны хаврын чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг батлуулах.



Холбогдох журам, аргачлалыг батлуулах.



Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн болон Хянан шалгах түр хорооны чиглэлээр хялбаршуулсан гарын авлага боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх.



Дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн гүйцэтгэлийн хэлэлцүүлэгт зориулсан шинжилгээний гарын авлагыг үе шаттай боловсруулах.



Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн явцыг хэлэлцэхэд шинжилгээ хийх арга зүйг боловсруулах.



Хуулийг сурталчлан таниулах чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.



Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан бий болгох ажлыг эхлүүлэх.



Үнэлгээний тайлан, үр дүнг сайжруулах, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр Швейцарын парламентын Тамгын газартай хамтран ажиллах.



Төсвийн төслийн үндэсний аюулгүй байдлын бодлоготой нийцэх нийцлийг тодорхойлох аргачлалыг боловсруулах.




Төсвийн хяналтын сонсгол явуулах бэлтгэл ажлыг хангах, удирдамж боловсруулах.

## Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа

2021 онд Улсын Их Хурал, Байнгын, дэд хорооны тогтоол, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий нийт 37 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 256 гишүүн ажиллахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.

Тайлант хугацаанд 2020 онд байгуулагдсан 9 ажлын хэсэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, 2021 онд 28 ажлын хэсэг шинээр байгуулагдсан нь өмнөх онтой харьцуулахад ажлын хэсгийн тоо 51.4 хувиар, ажилласан гишүүдийн тоо 59.8 хувиар өсчээ.

Ажлын хэсэг болон ажилласан гишүүдийн тоо



## Хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулагдсан шийдвэрийн төрөл:

Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан **2 Түр хороо**

Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан **18 ажлын хэсэг**

Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан **1 ажлын хэсэг**

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан **7 ажлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаатай танилцах **9 ажлын хэсэг**

Эдгээр ажлын хэсгүүдээс 2021 оны эцсийн байдлаар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 2, Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 4, байгууллагын үйл ажиллагаатай танилцах 9 буюу нийт 15 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэн санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газар болон холбогдох байгууллагуудад Улсын Их Хурлын 1 тогтоол, Байнгын хорооны 4 тогтоолоор тус тус үүрэг чиглэл өгч, үйл ажиллагаагаа өндөрлөсөн болно.

Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, Улсын Их Хурлаас баталсан хуулийнхаа хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үйл явцад иргэд, сонгогчид, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх замаар хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлуудтай газар дээр нь танилцах, цаашид хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр авах арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах, Улсын Их Хурлаас өгсөн үүрэг чиглэлийг Засгийн газар болон холбогдох байгууллагуудад хүргэх ажилд дэмжлэг үзүүлж ажиллав.

**Түр хороо, ажлын хэсгээс дараах ажлыг гүйцэтгэхэд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж ажиллав.**

### ***1. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан Түр хороо***

Улсын Их Хурлын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сартулам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах** үүрэг бүхий Түр хороо



Түр хорооны хуралдаан

Түр хороо цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Улсын онцгой комисс, Нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголбанк болон

Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн боловсролын газар зэрэг холбогдох байгууллагын 23 удаагийн танилцуулга, мэдээллийг сонсож, хэлэлцэв.

Түр хорооны хуралдаанаас Засгийн газар болон бусад байгууллагад 3 удаа үүрэг, чиглэл өгсөн байна.

Улсын Их Хурлын 2021 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан **“Оюутолгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах** үүрэг бүхий түр хороо

Түр хороо 12 удаа (хаалттай болон нээлттэй) хуралдаж, Рио Тинто группийн төлөөлөлтэй 2 удаа уулзалт хийж, Засгийн газарт 4 удаа үүрэг, чиглэл өгч ажилласан.

Түр хорооны 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Оюутолгой төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, говийн бүсийн газрын гүний ус ашиглалтын байгаль орчинд нөлөөлөх байдал болон холбогдох хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулах тухай 01 дүгээр тогтоолыг баталсан. Түүнчлэн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Оюутолгой ордоос Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2021 оны 103



Түр хорооны хуралдаан

дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн байна.

Түр хороо 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үйл ажиллагааны тайлангаа танилцуулснаар үйл ажиллагаа нь дуусгавар болсон.

## II. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг



Улсын Их Хурлын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 16 дугаар захирамжаар байгуулагдсан **Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах** чиг үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг ХӨСҮТ, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд байгуулагдсан дархлаажуулалтын цэгт ажиллаж, ажлын явцтай газар дээр нь танилцсан.

Ажлын хэсгээс Дархлаажуулалтын тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж дүгнэж, хуулийн төсөлд тусгах саналыг хүргүүлсэн бөгөөд үйл ажиллагааныхаа талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулан, олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна.



Ажлын хэсэг дархлаажуулалтын цэгт ажиллав.

Улсын Их Хурлын даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 18 дугаар захирамжаар байгуулагдсан **Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах** үүрэг бүхий ажлын хэсэг



Байнгын хорооны хуралдаан

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямаар ахлуулсан ажлын хэсэг хяналт шалгалтын ажлын хүрээнд Төрийн аудитын байгууллага, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний хөгжлийн газар, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-

иас Концессын гэрээний хэрэгжилтийн явц, 2014-2020 оны төмрийн хүдрийн экспорт, татварын өглөг зэрэг холбогдох мэдээллийг авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.



Хэвлэлийн бага хурал

Улсын Их Хурлын даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 28 дугаар захирамжаар байгуулагдсан **Хууль хяналтын байгууллагууд хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн  
Б.Энх-Амгалангаар ахлуулсан ажлын хэсэг  
Үндэсний аюулгүй байдлын

зөвлөлийн нэр бүхий албан хаагчид Алтанбулаг боомтоор их хэмжээний мөнгө оруулж ирсэн тухай асуудал болон нэр бүхий шүүгч, өмгөөлөгч нартай холбоотой хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаарх мэдээллийг холбогдох хянан шалгах эрх бүхий байгууллагуудаас авч танилцаж, үйл ажиллагааны тайланг Улсын Их Хурлын даргад танилцуулсан.

Түүнчлэн 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан хэвлэлийн бага хурлаар дээрх хяналт шалгалтын ажлын талаарх мэдээллийг олон нийтэд өгсөн байна.



Хууль зүйн байнгын хорооны хуралдаан

Улсын Их Хурлын даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 33 дугаар захирамжаар байгуулагдсан **Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгаж санал, дүгнэлт боловсруулах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын ахалсан ажлын хэсэг УБЕГ, АТГ, СЕХ,

УДШ-ийн Тамгын газраас үүсээд байгаа улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан мэдээлэл авсан бөгөөд ирүүлсэн тайлбар, мэдээлэлтэй холбогдуулан СЕХ, УБЕГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, нэмэлт мэдээлэл авсан.

Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанд ажлын хэсгийн тайлан, холбогдох санал, дүгнэлтээ танилцуулснаар ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



### III. Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг



Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан

“ 2021 онд Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан 15, дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсгийн 53 удаагийн хуралдааныг зохион байгуулах, хуралдааны дуу бичлэгийг цахим санд бүрдүүлэх, ажлын хэсэг орон нутагт ажиллахад техник, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж ажиллав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт "Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин**

**үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг**



Ажлын хэсгийн гишүүд Дундговь аймагт

Ажлын хэсэг "Боловсролын салбарын нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох" зорилтын хүрээнд ижил төрлийн төсөл хэрэгжүүлсэн байгууллага, ТББ-ын төлөөллийг оролцуулсан уулзалтыг Барилгын хөгжлийн төвд 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулав.

Түүнчлэн ажлын хэсгийн гишүүд Улаанбаатар хотын ойр орчимд нүхэн жорлонг стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар сольсон иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь очин танилцаж, ШУТИС дээр зохион байгуулсан бага оврын ариун цэврийн байгууламжуудын технологийн шийдэл танилцуулах арга хэмжээнд оролцож, сургууль, цэцэрлэг, дотуур

байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хэрэгжүүлэх талаар санал солилцов.

Ажлын хэсгийн гишүүд 2021 оны 10 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Дундговь аймгийн Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Гурвансайхан, Сайнцагаан сумдад ажиллаж, ариун цэврийн байгууламжийн угсралтын ажил, "Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөрийн явц байдалтай танилцсан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ажлын хэсгийн хуралдаанаар дэд ажлын хэсгийн үйл ажиллагааны явцтай танилцаж, хариуцсан яамдад үйл ажиллагаагаа уялдуулах чиглэл өгч, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.





Байнгын хорооны хуралдаан

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулагдсан **Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир,

спортын улсын хороо болон түүний харьяа нийслэлийн зарим дүүргийн спорт цогцолборын барилгын явцтай танилцаж, “Биеийн тамир, спорт: Шинжлэх ухаан ба хөгжил” цахим уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцүүлж, тус Байнгын хорооны 2021 оны 08 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор байгуулагдсан **Хүнсний тухай хуулийн хэрэгжилт буюу стратегийн хүнс болох улаан буудайн ургацын байдал, нөөц бүрдүүлэлт, борлуулалт, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, хангалтын байдал, үр шинэчлэлт, хангамжийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны ахалсан ажлын хэсэг 2021 оны 11 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Дархан-Уул аймгийн Дархан сум, Төв аймгийн Зуунмод, Жаргалант, Сүмбэр, Борнуур сумдад ажиллаж, ХХААХҮЯ-ны харьяа Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Сэлэнгэ салбар, Дархансалбар, Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг

“Өег” гурил, тэжээлийн үйлдвэр, ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаатай тус тус танилцав.



Ажлын хэсгийн гишүүд орон нутагт томилолтоор ажиллав.



Байнгын хорооны хуралдаан

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан **Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын ахалсан ажлын хэсэг Нийслэлийн эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин

судлалын үндэсний төв, Мэргэжлийн өвчин судлалын газрын ҮЭ-ийн хороо, Нийслэлийн Наркологийн эмнэлэг, Нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажилчдын ҮЭ-ийн хороо, Монголын эрүүл мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооноос ирүүлсэн санал, хүсэлттэй танилцаж, 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцэж, тус Байнгын хорооны 2021 оны 05 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн байна.



Байнгын хороодын хамтарсан хуралдаан

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хорооны хамтарсан **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт 2021 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны**

**явц байдалтай танилцан, шалгаж, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах** үүрэг бүхий ажлын хэсэг

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулсан ажлын хэсэг “Барилгын материалын үнийн өсөлтийн шалтгаан ба шийдэл” сэдвээр Барилга хот байгуулалтын яам, “Барилгын материалын үнийн өсөлтийн шалтгаан, коронавируст халдварын нөлөө” сэдвээр Сангийн яаман дээр цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсад барилгын материал үйлдвэрлэгчдийн төлөөлөл болох арматур, барилгын хөөсөнцөр, цемент, бетон зуурмаг үйлдвэрлэгчидтэй уулзаж, өнөөгийн байдал, цаашдын зорилт, үйл ажиллагааны талаар санал солилцов.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Төсвийн байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хамтарсан хуралдаанд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.

“ “ **Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан Улсын Их Хурал, Байнгын хорооны тогтоолыг тухай бүр хяналтад авч, биелэлтийг тооцон, Байнгын хороо бүрд харьяалах асуудлын дагуу танилцуулан ажиллаж байна.**

## Улсын Их Хурлын гишүүнээс асуулга, асуулт тавихад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн талаар

### Асуулга

Улсын Их Хурлын 59 гишүүнээс (давхардсан тоогоор) Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж,

ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж, 27 асуулгыг 133 асуудлаар тавьсан. Эдгээрээс чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуулгын хариуг хэлэлцүүлэн, давхардсан тоогоор 62 гишүүн 218 асуулт асууж, хариулт авав.

Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулга




### Асуулт

Улсын Их Хурлын 25 гишүүнээс (давхардсан тоогоор) Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан үйл ажиллагаатай нь

холбоотой тодорхой асуудлаар 23 асуултыг 81 асуудлаар тавихад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, тэдгээрийн хариуг хуульд заасан хугацаанд ирүүлэхэд хяналт тавьж ажиллав.

Улсын Их Хурлын гишүүний тавьсан асуулт





Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаан

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар тус бүр 2 асуултын хариуг хэлэлцүүлсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болов.



Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан

1. Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямаас Зам, тээврийн хөгжлийн сайдад хандан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын чанар болон гүйцэтгэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар” тавьсан 23 дугаар асуултын хариуг хэлэлцүүлж, Байнгын хорооны 2021 оны 13 дугаар тогтоолоор Дархан-Улаанбаатар хот хоорондын автозам барих ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Мөн Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгээс Зам, тээврийн хөгжлийн сайдад хандан “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны талаар” тавьсан асуултын хариуг

хэлэлцүүлсэн байна.

2. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос Эрчим хүчний сайдад хандан “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан баруун бүсэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ажлын хэрэгжилтийн талаар” тавьсан асуултын хариуг хэлэлцүүлэв.

Мөн тус Байнгын хорооны 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээс Монгол Улсын Шадар сайдад хандан “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн хэрэгжилт, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар” тавьсан 30 дугаар асуултын хариуг хэлэлцүүлсэн. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаарх асуултын хариуг Монгол Улсын шадар сайд танилцуулсан.

Асуултын хариутай холбогдуулан Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны “Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 2021 оны 04 дүгээр тогтоолоор Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн дагуу холбогдох журмуудыг батлуулах, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын асуудлыг шийдвэрлэх хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгөв.

## Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлсэн талаар



Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийв.

“ Монгол Улсын Ерөнхий сайд улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн байдал болон цаг үеийн тулгамдсан асуудлаар хийсэн 11 удаагийн мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулав.



Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн мэдээллийн талаарх 45 дугаар товхимол, 2021 оны хаврын

ээлжит чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийсэн мэдээллийн талаарх 46 дугаар товхимлыг тус тус хэвлүүлж, Улсын Их Хурлын гишүүд, орон нутаг дахь Иргэний танхимд хүргүүлэв.


## Байнгын, түр хорооны хуралдаанаар тайлан, мэдээлэл сонсох ажилд туслалцаа үзүүлсэн талаар

Монгол Улсын Их Хурлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хэлэлцэх цаглавар гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

2021 онд Байнгын болон дэд, түр хорооны хуралдаанаар эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын нийт 47 удаагийн

тайлан, мэдээллийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нийт 288 гишүүн (давхардсан тоогоор) 820 асуулт асууж, санал хэлж, тодорхой үүрэг чиглэл өгсөн.

Засгийн газрын болон холбогдох бусад байгууллагын хийсэн мэдээллийг өмнөх онтой харьцуулахад мэдээллийн тоо 2.1 дахин, асуулт асуусан гишүүдийн тоо 1.2 дахин, асуултын тоо 2.2 дахин өссөн байна.



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотой Түр хорооны хуралдаанаар **21**



Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан

Тайлан, мэдээлэл сонссонтой холбогдуулан Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаас гарсан

2 зөвлөмж, КОВИД-19-ийн Түр хорооноос гарсан 1 тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.



## Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн цахим сангийн үйл ажиллагааны талаар

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг дүгнэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг агуулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл

ажлын хүрээнд хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулах шийдэл, цахим системийн техникийн тодорхойлолтыг бэлтгэж, гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. Мэдээллийн нэгдсэн сангийн ажиллагаа, харилцан уялдаа холбоог хангах асуудлаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулж, шаардлагатай судалгаа, мэдээллийг бэлтгэв.

## Хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр

Тамгын газар 2021 онд хяналт шалгалт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах, холбогдох сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх замаар ажилтнуудын судалгааны арга зүй, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газар,

Швейцарын парламентын Тамгын газартай 2017 оноос эхлүүлсэн хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, Швейцарын парламентын хяналт шалгалтын газартай хамтарсан "Техникийн хамтын ажиллагааны үр дүн" мэдээлэл солилцох уулзалтыг 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа.



Швейцарын парламентын Тамгын газрын хяналт шалгалтын газартай хамтарсан "Техникийн хамтын ажиллагааны үр дүн" мэдээлэл солилцох уулзалт

Уулзалтад Швейцарын парламентын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын төслийн менежер Рауль Кензиг, Швейцарын парламентын Тамгын газрын Техникийн хамтын ажиллагааны нэгжийн

дарга Мариа Стосич нар оролцож, тус улсын парламентын Тамгын газрын хяналт шалгалтын чиг үүрэг, парламент дахь Хяналтын байнгын хорооны үйл ажиллагааны туршлагаасаа хуваалцлаа.



Тамгын газрын хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтнууд Ази, Номхон далайн үнэлгээний холбоо /APEA/-ноос зохион байгуулсан “Үнэлгээнд үндэслэн бодлого боловсруулах нь” олон улсын сургалтад оролцож, гэрчилгээ авлаа.





Цаашид Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах ажлыг тасралтгүй явуулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үр дүнтэй аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлж байна.






## 2.2. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ

Байнгын хороодоос ирүүлсэн саналд үндэслэн Улсын Их Хурлаас 2021 онд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх хууль тогтоомжийн цаглаврыг 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хурлын

Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант хугацаанд нийт 9 хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлэв.

### Нийт гүйцэтгэсэн хяналт шинжилгээ, үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

Байнгын хороо, гишүүд	Хууль тогтоомжийн нэр
 <p>ХЗБХ</p>	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлийн тайланд хийсэн үнэлгээ
 <p>ЭЗБХ</p>	Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
 <p>НББХ</p>	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
 <p>БСШУСБХ</p>	Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ

Байнгын хороо, гишүүд	Хууль тогтоомжийн нэр
 <p>Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт</p>	<p>Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ</p>
 <p>ЁЗСХБХ</p>	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ</p>
 <p>Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ</p>	<p>Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ</p>
 <p>БОХХААБХ</p>	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ</p>
 <p>ХЗБХ</p>	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ</p>



Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, түүнд хийсэн үнэлгээний үр дүнг Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар, Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 06 дугаар

сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн.

Үнэлгээний үр дүнг “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй

холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2021 оны 67 дугаар тогтоолд тусгаж батлуулсан нь Тамгын газраас хийж буй хяналт шинжилгээ, үнэлгээний үр нөлөө, ач холбогдлыг илэрхийлсэн үзүүлэлт юм.

Түүнчлэн, Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх хүрээнд хуулийн хэрэгжилтийг

үнэлэх, уг хуулийн харилцаанд оролцогч субъектүүдээс мэдээлэл авах, хууль хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж судалгаа хийх зорилгоор “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн үйл ажиллагаатай танилцаж, удирдлага, мэргэжилтнүүд болон паркийн нэгжийн төлөөлөлтэй уулзалт, ярилцлага хийв.



Ажлын хэсгийн хуралдаан

Мөн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаварын үнэлгээ хийх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн бирж болон Монголын ноос ноолуурын холбоо, Монголын брокеруудын холбоо зэрэг байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт, бүлгийн ярилцлага зохион байгуулж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд шаардлагатай мэдээлэл цуглуулав.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнг үндэслэн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоолоор “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, мөн “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

### **Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Тамгын газрын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээ**

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2020 оны хэрэгжилтийн явц, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээг хийж гүйцэтгэв.

Мөн дээрх журмын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас Улсын Их Хурлын Тамгын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд хариуцсан арга хэмжээний биелэлтийг сайжруулахад анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.

## Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагааны тайлангийн хяналт

Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн хороо, Төрийн албаны зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн

даатгалын ерөнхий газар 2020 оны үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээ хийсэн эсэхэд хяналт тавьж, санал, дүгнэлт боловсруулан холбогдох Байнгын хороодод хүргүүлээ.



### Улсын Их Хурлаас хяналтад авсан хууль тогтоомж

2021 оны байдлаар нийт 126 хуулийн 516 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 94 тогтоолын 296 заалт, Байнгын хорооны 96 тогтоол, тэмдэглэлийн 535 заалтыг хяналтад авсан байна.

		2019	2020	2021
<b>Монгол Улсын хууль</b>	Хяналтад байгаа хууль	101	103	126
	Хэсэг, заалт	515	391	516
<b>Улсын Их Хурлын тогтоол</b>	Хяналтад байгаа Улсын Их Хурлын тогтоол	81	84	94
	Заалт	268	314	296
<b>Байнгын хорооны тогтоол</b>	Хяналтад байгаа Байнгын хорооны тогтоол	98	76	96
	Заалт	668	408	535

Үүнээс 2021 онд шинээр 24 хуулийн 106 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 12 тогтоолын 51 заалт, Байнгын хорооны

17 тогтоол, тэмдэглэлийн 108 заалтыг бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

## 2.3. Төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр үзүүлсэн зөвлөгөө, туслалцаа

Улсын Их Хурлаас Улсын төсөвт хийх хяналт шалгалтыг төсвийн төлөвлөлтийн, төсвийн хэлэлцүүлгийн шатны, төсвийн

гүйцэтгэлд хийх хяналтын хэлбэрээр тогтмол хэрэгжүүлж хэвшлээ.

### Төсвийн төлөвлөлтийн хяналт:


Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь төсвийн тусгай шаардлага хангасан эсэхэд өмнөх онуудын төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, танилцуулга, холбогдох судалгаа, саналын хамтаар бэлтгэн Төсвийн байнгын хороонд хүргүүлж мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

### Төсвийн гүйцэтгэлийн хяналт:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахтай холбоотойгоор Сангийн яам, Үндэсний аудитын газраас ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

### Боловсруулсан бодлогын зөвлөмж, судалгаа, танилцуулга, санал дүгнэлтийн тоо

Төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр бодлогын зөвлөмж, судалгаа, санал дүгнэлт, танилцуулга 11 удаа хийсэн нь өнгөрсөн оныхоос 10 хувиар өссөн үзүүлэлт юм.



### Макро эдийн засаг, төсвийн талаарх мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байдал

Улсын нэгдсэн төсөв, мөнгөний нийлүүлэлт, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, албан нөөц, ажил эрхлэлт, бодит салбартай холбоотой цогц мэдээллийг багтаасан Монгол Улсын макро эдийн засгийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны I-III улирлын макро тойм судалгаа гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллав.

2020 оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны эхний 1-11 сарын гүйцэтгэлд тухай бүр дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн хүргүүлсэн бөгөөд эдгээр танилцуулгад Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр гаргаж тусгасан нь Улсын Их Хурлаас төсөвт тавих хяналтыг сайжруулах үр дүнтэй арга хэрэгсэл болж байна.

Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдэд Монгол Улсын нэгдсэн төсвийн

Мөн Монгол Улсын экспорт, импорт болон гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн экспорт, импортын тоо хэмжээ, үнэ ба татварын орлогод дүн шинжилгээ

хийж, товч танилцуулгыг сар бүр бэлтгэн Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод хүргүүлэв.


“” **Улсын болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээ, татварын өр, дутуу төвлөрсөн орлогын тайлбар, холбогдох тооцооллын талаарх мэдээллийг Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газраас авч боловсруулан, холбогдох танилцуулгыг 2021 оны 6 дугаар сараас эхлэн Улсын Их Хурлын цахим хуудас ([www.parliament.mn](http://www.parliament.mn))-т нийтэлдэг болсон нь төсвийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлсэн бодитой, үр дүнтэй ажил боллоо.**



### Бусад танилцуулга, мэдээлэл

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн, санал, дүгнэлт боловсруулж, Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэв.

Танилцуулгад 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар нэмэлт тооцоолол боловсруулж, эх үүсвэр тодорхойгүй төслүүдийн жагсаалтыг гаргасан.



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл болон эдийн засгийн нөхцөл байдлын талаар судалгаа, шинжилгээ хийж, танилцуулга, санал, зөвлөмж бэлтгэн Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн танилцуулгад тусгаж, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороог шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллалаа.

### Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүй, техникийн туслалцаа

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2021 онд нийт 14 удаа хуралдаж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулсан байна.

## 2.4. Дүгнэлт, зорилт

### Дүгнэлт


Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлахад шаардлагатай харьцуулсан судалгаа, лавлагааг бүрэн багтаасан “Хуулийн төслийн мэдээлэл, лавлагааны иж бүрдэл”-ээр Улсын Их Хурлын гишүүдийг хангаж, хэлэлцүүлгийн явцад 11 удаа багц мэдээлэл бэлтгэн, холбогдох ажлын хэсэгт зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажилласан нь парламентын хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна.

Уг хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Тамгын газраас 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж,

хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмуудыг боловсруулж, батлуулах, хүний нөөцийн чадавхыг сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

2021 онд Улсын Их Хурал, Байнгын, дэд хорооны тогтоол, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий 37 ажлын хэсэг (2 түр хороо)-т давхардсан тоогоор Улсын Их Хурлын 256 гишүүн ажиллахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

2020 онтой харьцуулахад ажлын хэсгийн тоо 51.4 хувь, гишүүдийн тоо 59.8 хувиар нэмэгдсэн байна.



Улсын төсвийн тухай хууль тогтоомжийн төсөл төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэхийг өмнөх онуудын төсөв, төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, танилцуулга, холбогдох судалгаа, саналыг Төсвийн байнгын хороонд хүргүүлж ажиллав. Мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020

оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны 1-11 дүгээр сарын гүйцэтгэлд тухай бүр дүн шинжилгээ хийж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр боловсруулан Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллав.



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ**

1. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, албан хаагчдыг чадавхжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулна.
  - 1.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хялбаршуулсан гарын авлага, танилцуулгыг боловсруулж, Улсын Их Хурлын гишүүд болон хянан шалгах үйл ажиллагаанд оролцогчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангана.
  - 1.2. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх арга зүй, зохион байгуулалтын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.
2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан журмуудыг баталж, мэдээллийн нэгдсэн сантай болно.
  - 2.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан “Улсын Их Хурлаас хэрэгжүүлэх хянан шалгах ажлыг зохион байгуулах” болон холбогдох бусад журмыг баталж, мөрдөнө.
  - 2.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг дүгнэх, хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг агуулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан бий болгож, ажиллах журмыг тогтооно.
  - 2.3. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх Тамгын газрын чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, холбогдох нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулна.
3. Парламентын хянан шалгах үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
  - 3.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг төрийн зарим байгууллагыг түшиглэн явуулах, тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулах ажлыг эхлүүлж, эрх зүйн зохицуулалт бий болгоно.
  - 3.2. Шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн, бодитой мэдээллээр хууль тогтоогчдыг хангах зорилгоор хуулийн төслийн зардал, үр нөлөөний тооцоолол, зардал бууруулах санал, дүгнэлт зэрэг мэдээллээр Улсын Их Хурлын гишүүдийг хангаж ажиллана.
  - 3.3. Богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төсвийн төсөлд шинжилгээ хийх аргачлалыг шинээр боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.



ТАРАХ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА



3.1. Улсын Их Хурлын үйл ажиллагааны цахим шилжилт

3.2. Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилт

3.3. Хуралдааны цахим системийн үйлчилгээ

3.4. Дүгнэлт, зорилт

	Иовал Зохих	Ирсэн	
Их хуралдай	25	19	59 / 75
Их эзэн Чингис хаан	17	12	
Жанжин Д.Сүхбаатар	15	12	78.7%
Үндсэн хууль	8	6	
Их засаг	10	10	
Цахимаар			



Улсын Их Хурлын Тамгын Газрын цахим шилжилтийг дэмжих дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн гурван цогц шинэчлэлийг хийв.

## III БҮЛЭГ

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

### 3.1. Улсын Их Хурлын үйл ажиллагааны цахим шилжилт

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд цахим шилжилт хийх стратегийн зорилтын хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулах, санал авах "lawmaker.parliament.mn", "lawforum.parliament.mn" цахим системүүдийн ашиглалтыг нэмэгдүүлж, Тамгын газрын дотоод

сүлжээнд иж бүрэн шинэчлэл хийж, техник, тоног, төхөөрөмжийг сайжруулан, интернэтийн нөөц урсгалыг бий болгож, "КОВИД-19" цар тахлын үед нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг цахим хэлбэрээр тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллав.

2021 онд "lawforum.parliament.mn" системд нийтлэгдсэн хууль тогтоомжийн тоо



**59**  
ХУУЛЬ ТОГТООМЖ



#### Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх цахим системийн ашиглалт

Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний 3.2.1-д заасан "Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, ил тод цахим парламент болох" зорилтын хүрээнд 2020 онд хөгжүүлэн нэвтрүүлсэн хууль санаачлагч олон нийттэй хамтран хуулийн төсөл боловсруулах "www.lawforum.parliament.mn" системд 2021 онд 59 хууль тогтоомжийн төслийг байршуулан, иргэдэд мэдээллийг хүргэснээр 98098 удаа (давхардсан тоогоор) хууль тогтоомжийн төсөлтэй танилцаж, олон нийтээс 1222 саналыг ирүүлжээ.

Тус системд бүртгэлтэй 1513 хэрэглэгч байгаагаас 1190 буюу 78.6 хувь нь бүртгэлээ баталгаажуулсан идэвхтэй хэрэглэгчид байна.


Системийн ашиглалтыг сайжруулах зорилгоор Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "lawmaker.parliament.mn" "lawforum.parliament.mn" цахим системээр үйлчлүүлсэн 1174 хэрэглэгчээс 234 буюу 20 хувийг хамруулсан хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийлгэв.



ХАНДАЛТ: **98098**



НЭВТЭРСЭН: **71110**



БҮРТГҮҮЛСЭН: **1513**



БҮРТГЭЛ  
БАТАЛГААЖСАН: **1190**

УЛСЫН ИХ ХУРАЛ, ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ДЭМЖИХ ДЭД БҮТЦИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН “ГУРВАН ЦОГЦ ШИНЭЧЛЭЛ”-ИЙГ ХИЙВ.

**ШИНЭЧЛЭЛ 1:**

**Дотоод сүлжээний IPTV-ийн шинэчлэл**

Нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг шууд дамжуулах интернэт телевизийн “iptv.parliament.mn” цахим хуудсыг шинээр хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлээ.

Энэхүү IPTV сувгийг бий болгосноор Улсын Их Хурлын гишүүд өөрийн албан хэрэгцээнд ашигладаг “СИМ” карт болон “Apple iPad” төхөөрөмж, ажлын компьютерээс нэгдсэн хуралдаан, Байнгын (дэд, түр) хороодын хуралдааныг онлайнаар шууд хүлээн авч үзэхээс гадна Тамгын газраас бэлтгэсэн цаг үеийн шуурхай мэдээ мэдээлэл, хуралдааны тов, хуваарь, судалгааны тойм, мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, видео контент зэргийг тогтмол хүлээн авах, улмаар мэдээллийн шуурхай урсгал бий болох боломж бүрдэв.

**ШИНЭЧЛЭЛ 2:**

**Сүлжээний шинэчлэл**

Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас хийсэн эрсдэлийн үнэлгээ, өгсөн зөвлөмжийн дагуу 2021 онд Тамгын газрын сүлжээний үндсэн тоног төхөөрөмжүүдийн тохиргоо, зохион байгуулалтыг шинэчлэн, интернэтийн нөөц сүлжээний холболт хийж, хамгаалалтын нөөц систем суурилуулж, ашиглагдаж байгаа бүх сервер компьютер, сүлжээний кабелиудыг хаягжуулан бүртгэлжүүлж, сервер, сүлжээний төхөөрөмжийн хяналт мониторингийн программыг суулган ашиглаж байна.



**ХҮРСЭН ҮР ДҮН**

**Сервер компьютер, зориулалтын шүүгээ**



Зориулалтын шүүгээ	9 →	<b>5</b>
Сервер компьютер	40 →	<b>20</b>

**Холболтын кабель**



Эмх цэгцгүй сүлжээний болон тэжээлийн кабелиуд	<b>Зориулалтын кабелийн замтай болгов.</b>
--	--

**Орчны параметр**



Зориулалтын бус цонх, халаалтын систем, хөргөлтийн систем	<b>Зориулалтын тааз, хөргөлтийн систем, дохиолол, мэдрэгч</b>
---	---


“ Тамгын газарт ашиглагдаж буй сервер, компьютеруудын үзүүлэлт, насжилт, ашиглалтын байдалд мониторинг хийж, серверийн техникийн үзүүлэлтийг нэмэгдүүлж, системүүдийг төрөлжүүлэн оновчтой зохион байгуулснаар идэвхтэй ашиглагддаг физик серверийн тоо 2 дахин буурч, төхөөрөмжийн ашиглалт эрс сайжрав.

### ШИНЭЧЛЭЛ 3: Серверийн өрөөний шинэчлэл

Хуралдааны цахим системийн тусгаарлагдсан сүлжээ болон компьютерийн дотоод сүлжээний серверийн өрөөнүүдийг иж бүрэн засварлаж, олон улсын стандартын дагуу зориулалтын шал, тааз, хөргөлт, чийгшил, агааржуулалтын систем, галын дохиолол, хөдөлгөөн мэдрэгч, хяналтын камераар бүрэн тоноглон, аюулгүй байдлын хяналт мониторингийн системүүдийг суурилууллаа.



ЧИЙГШИЛ:



“**Ингэснээр стандартад тохирсон орчинд ажиллаж буй төхөөрөмжийн ашиглалтын хугацаа уртасч, хэт халалт үүссэнээс болж төхөөрөмж шатах, серверийн өрөөнд ус алдах, сүлжээний тасалдал үүссэнээс болж үйлчилгээ удаан хугацаагаар тасалдах зэрэг өндөр эрсдэл үүсэхээс сэргийлэх бөгөөд хэн, хэзээ, хэрхэн серверт нэвтэрсэн, эсвэл гарсныг тодорхойлж, системийн аюулгүй байдлыг сайжруулав.**”

## 3.2. Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилт

### Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-ийн хөгжүүлэлт



2021 онд Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-д Тамгын газрын нийт албан хаагчдын хүний нөөцийн мэдээллийн баяжуулалтыг бүрэн оруулснаар 19 төрлийн судалгаа, мэдээллийг шуурхай, үнэн зөв гаргах боломжтой болов.

Албан хэрэг хөтлөлт, түүний эргэлтэд системээр хяналт тавьж, ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 7 хоног, сар, улирал, жилээр гарган Тамгын газрын удирдлагуудад танилцуулж хэвшүүлэв.

“**Үүний үр дүнд байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгч буй эсэхэд тогтмол хяналт тавих, бичиг хэргийн урсгалыг оновчтой төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдлээ.**”



Түүнчлэн 2021 онд “КОВИД-19” цар тахлын халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж, Тамгын газрын албан хаагчдын багагүй хувь нь халдвар авч, ажлын байран дээр ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн бөгөөд тухайн албан хаагчдыг зайнаас цахимаар ажиллуулан, ажлын гүйцэтгэлийг ERP системээр хянаж, үр дүнг тооцож ажиллав.

Хэрэглэгчдээс ирүүлсэн саналыг үндэслэн ERP системийн хөгжүүлэлтийн хүрээнд байгууллага, зохион байгуулалтын бүтцийн нэгж, ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг системээр боловсруулах, түүнийг хянах, нэгтгэх, үнэлэх болон баримт бичгийн төслийг боловсруулах, хянах, танилцуулах, баталгаажуулах ажиллагааг ERP системээр хийх техникийн даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгч компаниар системийн хөгжүүлэлтийг хийлгэв.

Үүний үр дүнд байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулан батлуулах, тайлагнах, удирдлагаас хянах, үр дүнг үнэлэх, албан бичгийн төлөвлөлтийг ажлын байр болон зайнаас цахимаар хийх боломжтой болсон нь байгууллагын цаасны хэрэглээг бууруулах, хугацаа хэмнэх ач холбогдолтой юм.

### Файлын нэгдсэн сангийн системийг нэвтрүүлэв.

“Улсын Их Хурлын Тамгын газрын файлын нэгдсэн сангийн “cloud.parliament.mn” системийг шинээр нэвтрүүлснээр байгууллагын дотоод системийн орчныг ашиглан ажилтнууд албан мэдээлэл, файл хадгалах, солилцох, хуваалцах, хамтран боловсруулалт хийх боломжийг бүрдүүлж, ашиглалт, хяналтын шаталсан тогтолцоо бүрдлээ.

Уг систем нь бичвэр, дуу, дүрстэй дуудлага хийх нэмэлт модультай бөгөөд байгууллагын өөрийн сервер компьютерт байрлан “Google Drive, Google Docs, Google Photos, Google Contacts” зэрэг түгээмэл ашиглагддаг багц програмуудтай ижил үүрэгтэйгээр ашиглагддаг онцлогтой юм.

Мөн ажлын байранд төдийгүй зайнаас цахимаар ажиллаж байгаа албан хаагчид дараах дотоод мэдээллийн сангуудыг цахим хэлбэрээр ашиглаж, албан үүргээ хэвийн гүйцэтгэх боломж бүрдсэн байна.


Үүнд:

- нэгж, ажилтнуудын албан хэрэгцээний файлууд;
- хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл (2001 оноос хойших);
- хуралдааны дүрсний бичлэг (2004 оноос хойших);
- хуралдааны дууны бичлэг (2011 оноос хойших);
- хууль, тогтоолын хувийн хэрэг;
- хуулийн сан;
- дүрэм, журмын сан.

## 3.3. Хуралдааны цахим системийн үйлчилгээ

Тамгын газрын Мэдээллийн технологийн хэлтэс Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын (дэд, түр) хороодын хуралдаан, ажлын хэсгийн хуралдааны техникийн бэлтгэл, бэлэн байдлыг ханган шаардлагатай засвар үйлчилгээг хийж, давхардсан тоогоор программ хангамжийн оператораар 300 удаа, дууны системийн оператораар 730 удаа, дүрсний системийн оператораар 350 удаа ажилласан байна.

### А. Хуралдааны системийн ашиглалт:



## Б. Операторын үйлчилгээний тоон мэдээлэл:



### Мэдээллийн технологийн үйлчилгээ

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан нэмэгдсэн цахим хэрэглээг хангах зорилгоор байгууллагын суурин интернэтийн 150mbps урсгалыг нэмэлт төлбөргүйгээр 650mbps болгон 4 дахин нэмэгдүүлсэн төдийгүй интернэтийн үйлчилгээний тасалдалгүй байдлыг хангахаар 30mbps урсгал бүхий нөөц интернэтийн сүлжээний холболтыг анх удаа хийлээ.

Олон нийтийн цахим сүлжээнд бий болсон Монгол Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Тамгын газрын нэр, бэлгэ тэмдгийг ашигласан хуурамч хаягуудыг хаалгах хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газарт гаргаж, “facebook”, “twitter”-ийн 8 хуурамч хаягийг хаалгаж, иргэд, олон нийтэд албан ёсны мэдээ, мэдээллийг хүргэх боломжийг бүрдүүлэв. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын (дэд, түр)

хороодын хуралдаан, ажлын хэсгийн хуралдааны техникийн бэлтгэлийг ханган, нийт 730 удаагийн хуралдаан болон бусад арга хэмжээнд 597 удаа цахим хуралдааны “Zoom” программын холболт хийж, операторын үйлчилгээг үзүүлснээс гадна Улсын Их Хурлын дарга, дэд дарга, гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргын оролцсон 20 удаагийн цахим хуралд зөврийн систем суурилуулан техникийн бэлтгэлийг ханган ажиллав.

Улсын Их Хурлын гишүүдийн албан хэрэгцээнд ашиглагддаг хөдөлгөөнт интернэтийн нэг сарын дата багц 6GB эрхтэй байсныг 2021 оны 10 дугаар сараас эхлэн 50GB болгон 8 дахин нэмэгдүүлэв.

## 3.4. Дүгнэлт, зорилт

### Дүгнэлт

“Цахим парламент” болох зорилтын хүрээнд Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилтийг дэмжих дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн гурван цогц шинэчлэл хийв.

Энэ хүрээнд Тамгын газрын серверийг 14 жилийн дараа шинэчилж, олон улсын стандартад нийцсэн аюулгүй байдлын хяналтын системийг суурилууллаа. Мөн хуралдааныг шууд дамжуулах интернэт телевизийн iptv.parliament.mn-ийг шинээр нэвтрүүлж, үйлчилгээний тасалдалгүй, найдвартай байдлыг хангасан интернэтийн нөөц урсгал бий болгов.

Үүний үр дүнд сервер, интернэтийн үйлчилгээний найдвартай байдал хангагдаж, Улсын Их Хурлын гишүүдэд цаг үеийн мэдээлэл, судалгааны тойм, нэвтрүүлэг, дүрст мэдээллийг шуурхай хүргэх боломж нэмэгдлээ.

2021 онд хуулийн төсөлд санал авах, хэлэлцүүлэх “lawforum.parliament.mn” системд нийт 59 хууль тогтоомжийн төслийг байршуулснаар иргэд, олон нийт 98098 удаа (давхардсан тоогоор) хууль тогтоомжийн төсөлтэй танилцаж, 1222 санал ирүүлсэн нь цахим систем ашиглан хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн



оролцоог хангах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал алхам болов.

Тамгын газраас 2020 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-ийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээ авсны үр дүнд ажлын цаг ашиглалт, албан

хэрэг хөтлөлт, түүнд тавих хяналт бүрэн цахимжлаа.

Тус системд тулгуурлан файлын нэгдсэн сан (cloud.parliament.mn) бий болгож, архивын материалтай цахимаар танилцах боломж бүрдсэнээр мэдээлэл солилцох, дамжуулах, хамтран ашиглах мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болж, ажлын бүтээмж, уялдаа холбоо сайжирч байна.


## 2022 оны зорилт

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ, ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, ПАРЛАМЕНТЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ҮР ДҮНД ХҮРГЭХ

1. Цахим парламент, инновацын тогтолцоо бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.
  - 1.1. Цахим парламент, инновацын бодлого хариуцсан нэгж байгуулж, олон улсын сайн жишигт тулгуурлан үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.
  - 1.2. Улсын Их Хурал, Тамгын газрын мэдээлэл солилцох нэгдсэн системийн эхлэлийг тавьж, албан хаагчдын мэдээлэл, өгөгдлийн дүн шинжилгээний чадавхыг сайжруулна
  - 1.3. Иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар авдаг “E-petition” цогц системийг олон улсын жишиг аргачлалын дагуу үйл ажиллагаандаа нэвтрүүлж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны цахим системийн шинэчлэлийг эхлүүлнэ.
  - 2.1. Нэгдсэн хуралдааны танхимын ирцийн бүртгэл, санал хураалтын системийг цахим хуралдааны программ хангамжийн хамт бүрэн шинэчилнэ.
  - 2.2. Цахим хуралдааны арга зүйг шинэчилж, биечлэн болон цахим оролцооны ялгааг арилгах, нэгдсэн тайлан гаргах боломж бүрдүүлнэ.
3. “D парламент” аппликэйшнийг нэвтрүүлж, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг шуурхай, хялбар аргаар олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлнэ.
  - 3.1. Иргэд, олон нийтэд парламентын үйл ажиллагааг сурталчлан таниулах, үйл ажиллагааны хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “D парламент” аппликэйшнийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.
  - 3.2. “lawforum.parliament.mn” системийн хэрэглэгчдийн үнэлгээний судалгаанд үндэслэн системийн ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийн төслийн мэдээллийг хэрэглэгчдэд хялбар, хүртээмжтэй хүргэх арга хэлбэрийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.
4. Тамгын газрын үйл ажиллагааны дотоод цахим системийн хэрэглээг хэвшүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилтыг үр дүнд хүргэнэ.
  - 4.1. Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-д тулгуурлан албан хэрэг хөтлөлт, өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт, төлөвлөгөө, тайлан, албан бичгийн боловсруулалтыг бүрэн цахимжуулна.
  - 4.2. Тамгын газрын үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүдийн ашиглалт, хэрэглээнд дүн шинжилгээ хийж, цаасны хэрэглээг 30 хүртэл хувиар бууруулна.
  - 4.3. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийн тогтолцоо нэвтрүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээ авна.



## УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

- 
- 4.1. Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр үзүүлсэн туслалцаа
  - 4.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр үзүүлсэн туслалцаа
  - 4.3. Парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил
  - 4.4. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд үзүүлсэн туслалцаа
  - 4.5. Дүгнэлт, зорилт



“Парламентын боловсрол”, “Өсвөрийн парламент” шинэ хөтөлбөрийг эхлүүлж, парламентын боловсрол, сургалтын дэд цахим хуудсуудыг ашиглалтад оруулснаар цахим технологи ашиглан олон нийтэд мэдлэг олгох, Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах нөхцөлийг бүрдүүлэв.

## IV БҮЛЭГ

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ПАРЛАМЕНТАД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН ТУСЛАЛЦАА

### 4.1. Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр үзүүлсэн тусалцаа

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үе шатанд иргэд, олон нийтийн оролцоог хангах, Улсын Их Хурлаас томилогдох албан тушаалтны талаарх олон нийтийн болон сонирхогч талуудын байр суурийг сонсох зорилгоор Байнгын, дэд, түр хороодоос нийтийн

сонсгол 2, олон нийтийн хэлэлцүүлэг 47, хурал, зөвлөгөөн 11, сургалт, семинар 4, уулзалт, ярилцлага 107 удаа зохион байгуулахад Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын тусалцааг үзүүлж ажиллалаа.

“Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр “Монгол Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам”-ыг батлав.

Хуульд заасан эрх бүхий байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, сонсголд оролцогч, сонсгол

даргалагчийн эрх хэмжээ, сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан гаргах асуудлыг тус журмаар нарийвчлан зохицуулсан байна.

#### БАЙНГЫН, ДЭД, ТҮР ХОРОО





*Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах томилгооны сонсгол*



*Авлигатай тэмцэх газрын дэд даргыг томилох томилгооны сонсгол*

Уг журмын дагуу Авлигатай тэмцэх газрын дэд даргыг томилох томилгооны сонсголыг 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчидтэй хийх томилгооны сонсголыг 2021 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд тус тус зохион байгуулав.

Сонсголд ажиглагч, оролцогчоор 21 хүн оролцож, нэр дэвшигч нараас асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газраас хоёр өдрийн турш олон нийтэд шууд дамжуулж ажиллав.

Мөн Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн

дарга Д.Ганбат нарын 37 гишүүнээс Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Хууль зүйн байнгын хороон дээр Нийтийн сонсгол зохион байгуулах саналыг 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хурлын даргад албан бичгээр ирүүлснийг үндэслэн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн тухай ерөнхий хяналтын сонсголыг Төрийн ордонд зохион байгууллаа.

Ерөнхий хяналтын сонсголд холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөл болон хүсэлт ирүүлсэн 3 ажиглагч, 18 оролцогч оролцсон.

Тамгын газар томилгооны болон ерөнхий хяналтын сонсголыг ил тод, нээлттэй зохион байгуулах, сонсголд иргэний нийгэм, иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулах, мэдээллийг цаг алдалгүй шуурхай дамжуулахад техник, зохион байгуулалтын туслалцааг үзүүлэн ажилласнаар төрийн үйл хэрэгт шууд оролцох иргэдийн эрхийг хангахад хувь нэмэр оруулж чадсан гэж дүгнэж байна.



*Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн тухай ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулав.*




## 4.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр үзүүлсэн туслалцаа

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал, Улсын онцгой комисс, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хорио цээрийн дэглэм, хязгаарлалттай холбоотойгоор Улсын Их Хурлын даргын 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 46 дугаар захирамжаар баталсан “Улсын

Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлах, мэдээлэх түр журам”-ыг 2021 оны I-III улиралд хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг мэдээллээр хангах, хэвлэлийн бага хуралд оролцуулах ажлыг шуурхай, хүртээмжтэй байдлаар зохион байгуулж ажиллалаа.

### БЭЛТГЭЖ, ТҮГЭЭСЭН МЭДЭЭЛЛИЙН ТОО



Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх ажлын хүрээнд Байнгын хороод, Чуулганы нэгдсэн хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, Байнгын хороодын дарга, гишүүд, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх 709 текст мэдээ бэлтгэж, 31.141 гэрэл зураг ашиглан parliament.mn сайтад нийтлэв.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын ээлжит чуулганы үйл ажиллагааны үр дүн, Улсын

Их Хурлын удирдлагын үйл ажиллагаа, цаг үеийн бусад асуудлаар Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газраас зарласан 74 удаагийн хэвлэлийн бага хурал, 52 удаагийн шууд дамжуулалт (Live)-ыг нэвтрүүлж, олон нийтэд хүргэв.

Түүнчлэн 2021 онд 10 телевиз, 13 цахим сайт, 2 радиотой тогтмол хамтран ажиллаж, нийт 109 байгууллагын 234 ажилтанд парламентын үйл ажиллагааг сурвалжлах үнэмлэх олгон, Улсын Их Хурлын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэлээ.



Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан

Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хороод, Тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой хэвлэлийн бага хурал зохион байгуулах, хууль, тогтоолын төсөл санаачлагч болон ажлын хэсгийн гишүүд, холбогдох бусад хүмүүсийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага (68 удаа) өгүүлэх ажлыг зохион байгуулж, тухай бүр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулж ажиллав.

Улсын Их Хурал, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын дарга, гишүүдийн томилолт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд батлагдсан хууль тогтоомжуудын шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийн талаар нийт 57 нэвтрүүлэг бэлтгэж, телевизүүдийн эфир, нийгмийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэв.

Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааны талаарх тойм нэвтрүүлэг 36-г бэлтгэж, телевиз, олон нийтийн сүлжээгээр дамжуулж, иргэдэд мэдээлэв.

Парламентын боловсрол олгох үйл ажиллагаагаар дамжуулан Монгол орны өнцөг булан бүрд байгаа хүүхэд

залуусыг нэгтгэх, тэдний дуу хоолой, оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилготой “Өсвөрийн парламент” хөтөлбөрийн талаар болон Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч Б.Чимидийн нэрэмжит долоо дахь удаагийн шагнал гардуулах ёслол, “Ковидын эсрэг Улсын Их Хурал”, “Улсын Их Хурал 2021” сэдэвт тус бүр 30 минутын нэвтрүүлгийг бэлтгэв.

Хууль санаачлагчаас боловсруулсан хуулийн төслийн гол зохицуулалтаар сонсогчдод шууд мэдээлэл хүргэх зорилгоор “88.3 MGL” радиогийн “Өнөөдөр Улаанбаатарт” нэвтрүүлгийн шууд эфирт Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагууд, зөвлөхүүдийг оролцуулж, парламентын үйл ажиллагаа, хэлэлцүүлгийн шатанд байгаа төслүүд болон батлагдсан хуулийн гол зохицуулалтын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг 32 удаа зохион байгууллаа.

Мөн Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран 14 хоног тутам бэлтгэдэг “Шинэ хууль” нэвтрүүлгийн 19 дугаарыг бэлтгэн сонсогчдод хүргэв.

### ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, АЖИЛТНЫ ТОО



## Нийгмийн сүлжээний ашиглалт, хандалт

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Parliament.mn цахим хуудас, нийгмийн

сүлжээ (Twitter.com, Facebook.com, Youtube.com, Instagram)-н дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хаягаар дамжуулан олон нийтэд шуурхай хүргэж ажиллав.




“**Улсын Их Хурлын Facebook дэх албан ёсны пэйж хуудасны дагагчдын тоо өмнөх жилийн мөн үеэс 22.3 хувь, Twitter хэрэглэгчдийн тоо 4.3 хувь, Youtube хэрэглэгчдийн тоо 20 хувь, Instagram хэрэглэгчдийн тоо 36.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.**

Нэвтрүүлгүүдийн зэрэгцээ үйл явдлын 238 постер, 95 инфографик, 170 видео мэдээ, социал контент, хууль сурталчлах шторк 16-г бэлтгэн хүргэжээ. Тодорхой сэдвийн хүрээнд өрөө үүсгэн ярилцдаг олон нийтийн харилцааны шинэ платформ болох клубхаус аппликэйшнд “Parliament of Mongolia” хаяг, аудио платформ болох soundcloud.com дээр “Монгол Улсын Их Хурал” хуудсыг шинээр нээв.

Төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн сүлжээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Парламентын подкаст” суваг бий болгож, эрхлэн хөтлөх арга хэмжээний бэлтгэлийг хангаж, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг гүйцэтгэн, студийн тохижилтыг хийж, контентийн агуулга, төлөвлөгөөг боловсруулаа.

## БУСАД БЭЛТГЭСЭН МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ТОО







“Монгол Улсад Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ой” сэдэвт шуудангийн маркийн нээлтийн арга хэмжээ.

## Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ойд зориулсан маркийн анхны өдрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.

“ Ийнхүү “Монгол Улсад Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ой” сэдэвт шуудангийн марк үнэт цаас болон баталгаажлаа.

Монгол Улсад ард түмнээ төлөөлөн төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага болох байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн түүхт ой 2020 онд тохиосон.

Энэхүү түүхэн үйл явдалд зориулсан шуудангийн хоёр нэрийн хэлхээ марк хэвлүүлсэн бөгөөд нээлтийн арга хэмжээг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулав.

## Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой сэдэвт шуудангийн маркийг хэвлүүлэв.



Монгол Улсын Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулсан “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой” сэдэвт шуудангийн блок маркийг хэвлүүлэв.

Энэхүү блок марканд Монголын ард түмний оюун санааны хамтын бүтээл, нийгмийн зөвшилцлийн эрхэм дээд тунхаг болсон Ардчилсан шинэ Үндсэн хуулийн анхны хэвлэмэл эхийг залсан ба чимэглэл хэсэгт мөнх хөх тэнгэрийн дор Монгол Улс үүрд мандан бадрахын бэлгэдэл болсон төрийн далбааны өнгөн дээр “гал мэт мандан бадарч, наран, саран мэт гэрэлтэн мөнхжиж, зөв сум мэт хурц шулуун, хуяг мэт бат бэх байж, загас мэт сонор соргог, өнөр өтгөн явж, арга билиг хослон, төмөр хүрээ лугаа адил төр улсаа хамгаалъя” гэсэн гүн утгатай алтан соёмбо тэмдэг, түүний дор “Монгол Улсын Үндсэн хууль” хэмээсэн үгийг эвхмэл бичгээр бичсэн болно.

## Хэвлэмэл бүтээгдэхүүн



Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс олгосон өргөмжлөл

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг хос бичгээр буюу монгол бичиг, кирилл үсгээр зэрэгцүүлэн хэвлэж байна. Тайлант хугацаанд “Төрийн мэдээлэл”-д хэвлэгдсэн хууль тогтоомжийн 37.7 хувийг монгол бичгээр хэвлэсэн.

### “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ” ЭМХЭТГЭЛД ХЭВЛЭГДСЭН ХУУЛЬ ТОГТООМЖ



### 4.3. Парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил

#### Парламентын боловсрол хөтөлбөр

Ардчилсан тогтолцоонд парламент ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг цогц, системтэй ойлгуулахаас гадна парламент үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төлөөллийг хангасан, ил тод, үр нөлөөтэй байх нь ямар чухал болохыг хүүхэд, залуучууд, олон нийтэд тайлбарлан сурталчлах зорилготой “Парламентын боловсрол хөтөлбөр”-ийг 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс нээж, Парламентын боловсрол олгох ажлыг эхлүүлээд байна.



“Парламентын боловсрол” хөтөлбөрийн нээлт



Монгол Улсын бүх хүн амд чиглүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх тус хөтөлбөрийг [www.edu.parliament.mn](http://www.edu.parliament.mn) цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэж байгаа бөгөөд хүүхэд залуучууд, насанд хүрэгчид хөтөлбөртэй танилцан Парламентын түүх, үйл ажиллагаа, үндсэн ойлголт болон төлөөллийн ардчилал, Үндсэн хуулийн талаарх мэдлэгийг олж авах боломжтой болов.

Тус хөтөлбөрийн хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран Парламентын боловсрол хөтөлбөрийн 12-14, 15-17 насны сурагчийн болон багшийн гарын авлага, 7 видео анимэйшн, дагалдах 34 хичээл, хэрэглэгдэхүүнийг боловсруулан бэлтгэж, хэрэглээнд нэвтрүүллээ.



“Парламентын боловсрол” хөтөлбөрийн гарын авлага



## Өсвөрийн парламент

Өсвөр үеийнхэнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаар мэдлэг ойлголт өгч, шийдвэр гаргах түвшинд өсвөр үеийнхний оролцоог нэмэгдүүлэх, дуу хоолойгоо шийдвэр гаргагчдад хүргэх боломжийг олгох зорилготой “Өсвөрийн парламент” хөтөлбөрийг Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо, Тамгын газар, НҮБ-ын Хүүхдийн сан, People in Need байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэв.



“Өсвөрийн парламент” хөтөлбөрт оролцогчидтой зохион байгуулсан “Өглөөний уулзалт”

Хөтөлбөрт оролцогчдын сонгон шалгаруулалтыг Ерөнхий боловсролын сургуулийн 9-11 дүгээр ангийн сурагчдын дунд Монгол орон даяар нээлттэй зарлаж, шалгаруулалтад оролцсон 907 сурагчаас 90 сурагчийг сонгон шалгаруулж, Өсвөрийн парламентын хөтөлбөрт хамруулав.

Тус хөтөлбөрийн хүрээнд хөтөлбөрт оролцогчид, сургагч багш нар Үндсэн

хууль, парламентын үйл ажиллагаа болон тогтвортой хөгжлийн зорилго, уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдал, агаарын бохирдлын эсрэг үе тэнгийнхэндээ ойлголт, мэдлэг өгөхөөс эхлээд үлгэрлэн дагуулахуйц бүтээлч ажил, санаачилгуудыг хэрэгжүүлж, дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

2021.09.25  
Сургагч багш  
бэлтгэх сургалт  
зохион байгуулав.

1

Оролцогчдод 7 хоног бүр хоёр сэдвээр хичээл орж, Үндсэн хууль, ардчилал, сонгууль, парламент, Улсын Их Хурал, хууль бүтээх үйл ажиллагааны талаар мэдлэг олгов.

3

2021.10.02  
Хөтөлбөрийг нээж,  
Улсын Их Хурлын дарга  
Г.Занданшатар “Хүний эрх-  
Ардын эрх” сэдвээр анхны  
хичээлийг заав.

2

4

2021.11.20  
Дэлхийн хүүхдийн өдрийг  
тохиолдуулан Улсын Их Хурлын  
дарга Г.Занданшатар болон  
Улсын Их Хурлын Ерөнхий нарийн  
бичгийн дарга Л.Өлзийсайхан нар  
Өсвөрийн парламент хөтөлбөрийн  
оролцогч 25 хүүхэдтэй өглөөний  
уулзалт зохион байгуулав.



#### 4.4. Улсын Их Хуралд иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд үзүүлсэн туслалцаа

2021 онд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодод хандаж 11197 иргэн (давхардсан тоогоор)-ээс нийт 2645 өргөдөл ирүүлсэн бөгөөд үүнээс 176 буюу 6.7 хувь нь иргэдийн санал, 169 буюу 6.5 хувь нь гомдол, 136 буюу 5.2 хувь нь шаардлага, 2164 буюу 81.8 хувь нь хувийн асуудлаар хандсан өргөдөл байна.


Нийт өргөдлийн 1697 буюу 64.2 хувь нь нийслэлийн иргэдээс, 634 буюу 23.9 хувь нь хөдөө, орон нутгийн иргэдээс ирсэн бол 314 буюу 11.9 хувийг хаяг тодорхойгүй өргөдөл эзэлж байна.


2021 онд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо хамтран 1178 өргөдөл, гомдол буюу 44.5 хувийг бүрэн шийдвэрлэсэн бөгөөд 1467 буюу 55.5 хувийг судалж шийдвэрлэх шатанд байна.

2021 онд Иргэдийг хүлээн авах байранд 121 иргэн утсаар болон биечлэн ирж санал, хүсэлт гаргасан бол Улсын Их Хурлын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хэлэлцэж буй хууль тогтоомжийн төсөл, нийтэд тулгарч буй асуудлын талаарх 27 иргэний санал, 38 иргэний хувийн хүсэлтийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэж хариу өгөхөд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.

Мөн [www.11-11.mn](http://www.11-11.mn) цахим хуудсаар Улсын Их Хурлын гишүүдэд болон Байнгын хороо, намын бүлэг, Тамгын газарт хандсан 162 санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархал ирүүлснийг гишүүдийн туслах, намын бүлгүүдийн ажлын албаар дамжуулан танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.


Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, шаардлага






**64.2%**

НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭД




**23.9%**

ОРОН НУТГИЙН  
ИРГЭД



**11.9%**

ХАЯГ  
ТОДОРХОЙГУЙ



[www.11-11.mn](http://www.11-11.mn)

**162**

ЦАХИМ  
ХУУДАС

## 4.5. Дүгнэлт, зорилт

### Дүгнэлт

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрүүдийн төсөлд олон нийтийн саналыг авах, хууль, бусад шийдвэрийг тайлбарлан таниулах чиглэлээр нийт 49 арга хэмжээг хэрэгжүүлж, Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсгийн 167 удаагийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол, хурал, уулзалтыг зохион байгуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллажээ.

Тухайлбал, Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, сонсголд оролцогч, сонсгол даргалагчийн эрх хэмжээ, сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан гаргах асуудлыг нарийвчлан зохицуулсан “Монгол Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам”-ыг Улсын Их Хурлаас батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Уг журмын дагуу Авлигатай тэмцэх газрын дэд дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчдийн томилгооны сонсголыг зохион байгуулснаар Улсын Их Хурлаас томилогдох албан тушаалтныг нээлттэй сонсгол явуулсны үндсэн дээр томилох үйл ажиллагаа албан ёсны тогтолцоо болж, түүнийг хэрэгжүүлж ажиллах Тамгын газрын чадавх сайжирч байна.

Батлагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн

дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хаягуудаар дамжуулан хүртээмжтэй, тасралтгүй, шуурхай хүргэж ажилласны дүнд олон нийтийн цахим сүлжээн дэх хэрэглэгчдийн тоо 2020 онтой харьцуулахад 4.3-36.4 хувиар өсчээ.

Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулсан “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой” маркийг хэвлүүлж, “Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ой” сэдэвт маркийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Түүхэн ойд зориулсан эдгээр маркууд нь олон улсад манай парламентын ардчиллын түүх, хөгжлийг таниулан сурталчлах шинэлэг, бодитой алхам болов.

2021 онд Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас “Парламентын боловсрол” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх шинэ механизм бүрдэж, [edu.parliament.mn](http://edu.parliament.mn) цахим хуудас, Парламентын боловсролын сургалтын хөтөлбөр, гарын авлагатай болов.

“Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг анх удаа зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн 9-11 дүгээр ангийн 90 сурагчийг хамруулан ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх ойлголт өгч, шийдвэр гаргах түвшинд бодитой оролцох боломжийг нь дэмжлээ.

Ингэснээр Монгол Улсын парламент дэлхийн бусад улс орны парламентуудын нэгэн адил өсвөр үе, залуучуудад зориулсан сургалтын тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлдэг шинэ жишиг тогтох эхлэлийг тавив.

## НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ИРГЭДИЙН ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

1. Парламентын нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
  - 1.1. “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв”-үүдийг орон нутагт байгуулах оновчтой шийдлийг боловсруулж, шийдвэрлүүлнэ.
  - 1.2. Улсын Их Хурлын дэргэд Парламентын музей, Парламентын сургалтын танхим байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.
2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд оновчтой зохион байгуулж, хэрэгжүүлнэ.
  - 2.1. Дүрст болон нийгмийн сүлжээний контентийн форматыг сайжруулж, аудио болон видео подкастаар мэдээлэл хүргэх ажлыг шинээр эхлүүлнэ.
  - 2.2. “www.parliament.mn” цахим хуудсыг дэлхийн парламентуудын жишигт нийцүүлэн шинэчилнэ.
  - 2.3. Улсын Их Хурлын танилцуулгыг монгол, англи хэл дээр шинэчлэн хэвлүүлж, шинэлэг агуулгаар баяжуулна.
3. Улсын Их Хурлын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, техникийн шинэчлэлийг эхлүүлж, албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлнэ.
  - 3.1. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, техникийн шинэчлэлийг эхлүүлнэ.
  - 3.2. Хэлтсийн үйл ажиллагаанд дэлхийн улс орнуудын парламентын туршлагыг нэвтрүүлж, энэ зорилгоор албан хаагчдыг сургалтад хамруулна.
  - 3.3. “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг монгол бичгээр бэлтгэхэд шаардлагатай хөрвүүлгийн программ эзэмшиж, “Хуралдай” фонтыг хэрэглээнд нэвтрүүлэн, сайтын мэдээллийн 10-15 хувийг монгол бичигт шилжүүлнэ.
4. “Парламентын боловсрол” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлнэ.
  - 4.1. “Парламентын боловсрол” хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан хэрэгжүүлж, иргэддээ ардчилал, хүний эрх, Үндсэн хуульт болон парламентат ёсны мэдлэг, боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.
  - 4.2. Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан “Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
  - 4.3. Оюутан залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан Парламентын боловсролын гарын авлага боловсруулан, залуучуудын дунд парламентын мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулж, Үндсэн хуульт болон парламентат ёсны мэдлэг олгох ажлыг эрчимжүүлнэ.



## ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ

- 5.1. Судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангахтай холбоотой үйл ажиллагаа
- 5.2. Парламентын номын сан
- 5.3. Парламентын сургалт
- 5.4. Дүгнэлт, зорилт



Улсын Их Хурлаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлах, боловсруулж хэлэлцэн батлахад дэмжлэг үзүүлж, мэдээлэл лавлагаагаар хангах шинжлэх ухааны үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа, бүтээгдэхүүний тоо өмнөх оноос 40 хувиар өсөв.

## V БҮЛЭГ

# ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ


### 5.1. Судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангахтай холбоотой үйл ажиллагаа

Тамгын газрын Парламентын судалгааны хүрээлэн 2021 онд Улсын Их Хурлын гишүүд хууль тогтоомжийн төсөл санаачлан боловсруулах, Улсын Их Хурлаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлахад шаардагдах нийт 81 судалгааны ажил хийж гүйцэтгэлээ.

Үүнээс Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагын захиалгаар 69, төлөвлөгөөт 12 судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд бүтээгдэхүүний төрлөөр авч үзвэл, харьцуулсан судалгаа 54, мэдээлэл лавлагаа 19, дүн шинжилгээ 5, тойм судалгаа 2, контент анализ 1-ийг тус тус бэлтгэв.

“**Өмнөх онтой харьцуулахад судалгааны захиалга болон гүйцэтгэсэн судалгааны тоо 40 хувиар, Улсын Их Хурлын гишүүдийн захиалгат судалгаа 3 дахин, төлөвлөгөөт судалгаа 2 дахин тус тус нэмэгдсэн байна.**

#### СУДАЛГААНЫ ТОО



Байнгын хороодын захиалгаар



Улсын Их Хурлын гишүүний захиалгаар



Тамгын газрын удирдлагын захиалгаар



Бусад (төлөвлөгөөт судалгаа)

## СУДАЛГААНЫ ЗАХИАЛГЫГ ЗАХИАЛАГЧИЙН ТӨРЛӨӨР НЬ АВЧ ҮЗВЭЛ

### Байнгын хороодын захиалгат судалгаа:



### Улсын Их Хурлын гишүүдийн захиалгат судалгаа:

- Цахим засаглал, бодлого болон тоон гарын үсэгтэй холбоотой эрх зүйн харьцуулсан судалгаа (2020.12.21)
- Хот, тосгоны эрх зүйн байдал, бусад орны туршлага (2021.01.06)
- Зарим орны улсын болон уул уурхайн салбарын дундаж цалингийн талаарх мэдээлэл лавлагаа (2021.01.14)
- Генетик нөөцийн эрх зүйн зохицуулалт, бусад орны туршлага (2021.01.29)
- Үндсэн хууль болон бусад хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийн талаарх лавлагаа (2021.02.01)
- Удмын сангийн бодлого, түүнийг хамгаалах, зохицуулахтай холбогдсон эрх зүйн баримт бичгийн харьцуулсан судалгаа (Олон улсын зөвлөмж ба бусад орнуудын сайн туршлага) (2021.02.03)
- Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн бүлийн зарим орны парламентын хуралдааны дэгийн зарим зохицуулалт (2021.02.08)
- Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл, лавлагаа (2021.02.09)
- Телемедицин үйлчилгээний эрх зүйн зохицуулалт: Гадаадын зарим орны туршлага (БНХАУ, БНСУ, Филиппин, Малайз, Австрали, ОХУ, Япон) (2021.02.17)
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын зохицуулалт: Гадаадын зарим орны туршлага (2021.02.17)
- Гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: Бусад орнуудын туршлага (2021.02.19)
- Морин тойруулгын бооцоот уралдааны эрх зүйн харьцуулсан судалгаа (2021.04.19)
- Гадаадын зарим орны гадаадын иргэн харьяат, цагаачлалын асуудал хариуцсан байгууллагын статус, чиг үүрэг болон албан хаагчдын төрийн албаны ангилал (2021.03.22)
- Нэмэгдсэн өртгийн албан татварын чөлөөлөл: "Монгол Улсын нөхцөл байдал ба гадаадын зарим орны туршлага" (2021.03.23)

- Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дагалдах хууль, журмуудын талаарх лавлагаа мэдээлэл (2021.03.25)
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний талаарх харьцуулсан лавлагаа мэдээлэл: Монгол Улс болон гадаадын зарим орны мэдээлэл (2021.04.24)
- Цахим орчинд үйлдэгдэж буй хүчирхийлэл, хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалт: олон улсын туршлага (2021.04.26)
- Зарим орны жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого ба санхүүжилтийн тогтолцоо (2021.04.26)
- Зөвшөөрлийн ангилал, төрөл ба түүнийг олгох, хянахтай холбоотой эрх зүйн зохицуулалт: Гадаадын зарим орны туршлага (2021.05.12)
- “КОВИД-19” цар тахалтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний санхүүжилтийн ил тод байдал (Авлигын үзүүлэлттэй хамааралтай эсэх) (2021.05.18)
- Төрийн (нийтийн) албаны тогтолцоо ба эрх зүйн орчин: Ангилал, улс төрийн албан тушаалтанд тавигддаг шаардлага, ёс зүй, сахилга хариуцлага (2021.05.27)
- Кибер аюулгүй байдлын олон улсын зохицуулалт (2021.06.11)
- Монгол Улс дахь уул уурхайн зам, тээврийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, түүний эдийн засагт үзүүлэх нөлөө, үр ашиг (2021.06.29)
- Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоо ба цалин хөлсний систем: Олон улсын туршлага, зөвлөмж (2021.07.08)
- Монгол Улсын макро эдийн засаг, нийгмийн амьдралд цар тахлын үзүүлсэн нөлөөлөл ба алдагдсан боломжийн зардал (2021.07.21)
- Франчайзингийн гэрээний эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага (2021.08.06)
- Хууль сурталчлах үйл ажиллагааны талаарх бусад орнуудын туршлага: Хууль сурталчлах үйл ажиллагаан дахь парламентын оролцоо (2021.10.01)
- Газрын тосны харилцааны эрх зүйн зохицуулалт: Бусад орнуудын туршлага (2021.10.09)
- Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж, хүүхэд асрах чөлөөний талаарх гадаадын зарим орны туршлага (2021.10.14)
- Нийгмийн даатгал төлөлтөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамрагдалт: Монгол Улсын нөхцөл байдал (2021.10.20)
- Гүрж Улсын Лиценз ба зөвшөөрлийн тухай хууль (2021.10.22)
- Малчдын боловсролын талаарх лавлагаа мэдээлэл (2021.10.23)
- Ашигт малтмалын хайгуул, олборлох үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит уул уурхайн компаниудын олон улсын туршлага (2021.11.04)
- Цахим гарын үсгийн эрх зүйн зохицуулалтын олон улсын чиг хандлага: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага (2021.11.08)
- Хувийн мэдээлэл хамгаалах талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт (2021.11.12)
- Тэтгэврийн хуримтлалын тогтолцооны талаарх гадаадын зарим орны туршлага (2021.11.16)
- Монгол Улсын сэтгэл судлалын салбарын өнөөгийн байдал, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоо ба гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалт (2021.11.17)
- Нийтийн мэдээллийн эрх зүйн зохицуулалт (2021.11.23)
- Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага ба эрх зүйн орчин (2021.11.25)
- Дэлхийн улс орнуудын парламентын хөгжлийн өнөөгийн байдал ба орчин үеийн чиг хандлага (2021.12.01)
- Мах, махан бүтээгдэхүүн болон сүү, сүүн бүтээгдэхүүн бэлтгэлийн талаарх лавлагаа мэдээлэл (2021.12.13)
- Газрын тосны нөөц бүрдүүлэх эрх зүйн зохицуулалт: Олон улсын туршлага (2021.12.16)
- Парламентын гишүүний ёс зүйн дүрэм, түүнд хяналт тавих эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим орны туршлага (2021.12.24)

## Эрхлэн гаргасан ном, товхимол, сэтгүүл:

Парламентын судалгааны хүрээлэн 2021 онд ном товхимол, гарын авлага эмхэтгэж хэвлүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж, Улсын Их Хурлын хууль тогтоох үйл

ажиллагааны бүтээмжийг сайжруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээгээр хангав. Үүнд:



“Парламент” судалгааны эмхэтгэл цуврал ботийн 32, 33, 34, 35 дахь дугаар



“Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа” цуврал эмхэтгэлийн 26, 27 дахь дугаар



Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны болон хүндэтгэлийн хуралдааны танилцуулга



Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит, 2022 оны ээлжит бус чуулганы үйл ажиллагааны болон хүндэтгэлийн хуралдааны танилцуулга



“Парламентын судалгаа, шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл



“Мэдээлэл судалгаа” мэдээллийн хуудасны 25 дугаар

*Парламентын судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргасан ном, товхимол, сэтгүүл*

“Мэдээлэл судалгаа” аналитик тойм мэдээллийн нийт 25 дугаарыг эрхлэн гаргаж, Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудалтай холбоотой судалгаа, мэдээллээр Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагуудыг хангав. Үүнд:



#### НЭГДҮГЭЭР САР

Монгол Улс дахь хүний эрхийн хамгаалагчийн нөхцөл байдал, олон улсын баримт бичиг



Улс төрийн намын санхүүжилтийн нөхцөл байдал



#### ХОЁРДУГААР САР

Парламентын хяналт шалгалт



#### ГУРАВДУГААР САР

Монгол Улсын хот, тосгоны өнөөгийн байдал, бусад орны туршлага



Гадаад худалдааны бодлого, Монгол Улсын уул уурхайн бус экспортын салбарын нөхцөл байдлын мэдээлэл 2010-2020 он



Хүмүүнлэг боловсрол, бусад орны туршлага



Монгол Улсын гадаад өр



#### ДӨРӨВДҮГЭЭР САР

Ковид-19 цар тахал хэзээ дуусах вэ? Тархалтын таамаглал



#### ЗУРГААДУГААР САР

Бичил уурхай ба гар аргаар ашигт малтмал олборлолт



#### ТАВДУГААР САР

Тэтгэврийн тогтолцоо



Хөрөнгө оруулалтын банк



Мөнгө угаах,  
терроризмыг  
санхүүжүүлэх  
гэмт хэрэг



Парламентын  
хянан шалгах  
түр хороо



ДОЛООДУГААР САР  
Төрийн аудитын  
тухай



Виртуал хөрөнгө,  
криптовалютын  
зах зээл



Франчайзингийн эрх  
зүйн зохицуулалт,  
нөхцөл байдал



АРВАН ХОЁРДУГААР САР  
Зөрчил шалган  
шийдвэрлэх эрх зүйн  
зохицуулалт



Чөлөөт бүс буюу  
эдийн засгийн  
тусгай бүс



НАЙМДУГААР САР  
Хөгжлийн  
бодлого,  
төлөвлөлт



Цахим орчин  
дахь хүүхдийн  
хүчирхийлэл

Төсвийн үйл  
явц дахь  
парламентын  
оролцоо, 2022  
оны төсвийн  
шинжилгээ



АРВАН НЭГДҮГЭЭР САР  
Улс төрийн намын  
бүртгэл, гишүүнчлэл



ЕСДҮГЭЭР САР  
Кибер аюулгүй  
байдал



АРАВДУГААР САР  
Донорын  
тухай эрх зүйн  
зохицуулалт,  
нөхцөл байдал

## 5.2. Парламентын номын сан

Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний 5.1.3-т тусгасан “Парламентын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, уншлагын, цахим мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлдэг болгох” арга хэмжээний хүрээнд номын сангийн цахим систем (КОХА)-ийн шинэчлэлийн ажлыг зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд техникийн даалгавар, гэрээний шаардлагын дагуу хяналт тавин ажиллав.

Улсын Их Хурлын 2021 оны хавар, намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлаар Парламентын номын сангаас ном товхимлын (638), тогтмол хэвлэл (өдөр тутмын 8 сонин, 7 сэтгүүл)-ийн ном зүйн мэдээлэл (нийт 880 нэгж)-ийг түүвэрлэн 4 удаа лавлагаа боловсруулж, хөдөлгөөнт оффисийн “MyParliament” цахим системд байршуулан ажиллав.

Парламентын номын сангаар 2021 онд 2812 уншигч үйлчлүүлснээс 511 уншигчид

1530 ном гэрээр олгож, 51 уншигчид 110 тогтмол хэвлэлийн нэгжээр, 1150 уншигчид лавлагаа, ном зүйгээр, 1100 уншигчид уншлагын танхимаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтээр тогтмол хэвлэлээс сэдэвчилсэн түүвэр хийж, арга зүйн туслалцаа үзүүлэн ажилласнаас гадна Үндсэн хуультай холбоотой ном, товхимлын лавлагаа, Парламентын судалгааны хүрээлэнгээс боловсруулж буй судалгаатай холбоотой эх сурвалжийн сэдэвчилсэн лавлагааг тухай бүр гарган мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэв.

2021 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Номын баяр - Номын танилцуулга” арга хэмжээний хүрээнд 500 гаруй ном, товхимлоор сэдэвчилсэн үзэсгэлэн дэлгэж сурталчиллаа.



Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдсан “Номын баяр - Номын танилцуулга” арга хэмжээ

Үйлчилгээний төрөл	2021 он
Уншлагын танхимын үйлчилгээ	1100 уншигч
Гэрээр ном олгох	511 уншигч /1530 ном хэвлэл
Худалдан авсан ном	9,3 сая төгрөг 276 ш ном
Хандиваар авсан ном	310 ш ном
Хөгжлийн мэдээллийн төв	114 ном товхимол
Лавлагаа, ном зүйн үйлчилгээ	1150 уншигч
Улсын Их Хурлын чуулганы хэлэлцэх асуудлаар тогтмол хэвлэл, ном товхимлын лавлагаа	4 удаа
Цахим үйлчилгээ (Research For Life мэдээллийн сан/ Flipster дижитал сэтгүүлийн сан)	167 хандалт
Номын үзэсгэлэн	1 удаа 4000 оролцогч




### 5.3. Парламентын сургалт

Улсын Их Хурлын гишүүд, түүний ажлын албаны ажилтнууд болон Тамгын газрын нийт ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, холбогдох ном, эмхэтгэл, гарын авлагаар хангах чиг үүргийн хүрээнд 2021 онд нийт 49 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж,

2200 албан хаагч (давхардсан тоогоор)-ийг хамруулав. Өмнөх онтой харьцуулахад зохион байгуулсан сургалтын тоо 2 дахин, сургалтад оролцогчдын тоо 2.5 дахин өсч, сургалтын хүртээмж нэмэгдсэн байна.

#### СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



#### Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан сургалт, хэлэлцүүлэг

Парламентын судалгааны хүрээлэн 2021 онд Улсын Их Хурлын 18, 29 дүгээр тойрогт явагдсан нөхөн сонгуулийн үр дүнгээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан чиглүүлэх сургалтыг хийлээ.

Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүд АНУ-ын Конгресс, ХБНГУ-ын Бундестагийн гишүүдтэй туршлага судлах, мэдээлэл солилцох 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.



Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан чиглүүлэх сургалт



Цахим уулзалт, хэлэлцүүлэг

## Тамгын газрын ажилтны сургалт

“Парламентын сургалтын цогц хөтөлбөр”-ийн дагуу Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулах 37 удаагийн сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, 2024 ажилтан (давхардсан тоогоор) хамрагдав. Энэ онд Тамгын газрын албан хаагчдын мэргэжлийн хөгжлийг дэмжих, хувь хүний хөгжлийн

мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд сургалтын сэдэв, агуулгыг чиглүүлсэн. Энэ зорилтын дагуу эрх зүйн дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих арга зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр дараах сургалтыг зохион байгуулав.



Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулах сургалт



Үндэсний статистикийн хороотой хамтран статистик, тоон мэдээллийн хэрэглээ, тооцох арга зүйн асуудлаар 5 удаагийн цуврал сургалтыг явуулсан нь Тамгын газрын албан хаагчид статистикийн

мэдээллийг үр дүнтэй ашиглаж, бэлтгэн гаргаж буй судалгаа, мэдээллийн чанарыг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

## Олон нийтийн хэлэлцүүлэг

2021 онд Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлаар төрийн болон иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачид, олон нийтийн оролцоотой 5 удаагийн хэлэлцүүлэг болов.

Тамгын газар Япон Улсын Элчин сайдын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Япон лугаа хөгжье” цуврал хэлэлцүүлгийг дараах сэдвээр зохион байгууллаа.



Хэлэлцүүлэг



**2021.04.14**

Үндсэн хуулийн өөрчлөлт ба хөгжлийн загварыг тодорхойлох нь



**2021.09.30**

Боловсролын шинэчлэл ба хүмүүнлэг боловсрол



**2021.12.01**

Эдийн засаг, аж үйлдвэрийн бодлого, Япон Улсын эдийн засаг худалдаа, аж үйлдвэрийн яамны чиг үүрэг



**2021.12.22**

Эдийн засгийн төлөвлөлт ба хөгжлийн бодлого төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Түүнчлэн, төрийн бодлого, шийдвэрт их өгөгдөл (Big data)-ийг ашиглах, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх талаар сонирхогч талуудыг

оролцуулсан хэлэлцүүлгийг Үндэсний статистикийн хороотой хамтран 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулж ажиллав.



Хэлэлцүүлэг

## Сургалтын дэд хөтөлбөр, цахим систем



<https://training.parliament.mn>

2020 онд баталсан “Парламентын сургалтын цогц хөтөлбөр” нь 7 үндсэн, 30 дэд хөтөлбөртэй. Энэ онд эдгээрээс 15 дэд хөтөлбөрийн сэдэв, агуулгын хүрээг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх бэлтгэлийг хангав.

Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан “Монгол Улсын хууль тогтоох үйл ажиллагаа ба Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх”, Тамгын газрын ажилтнуудын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор “Хуулийн төсөл боловсруулагчийн анхан болон ахисан шатны”, салбар дундын мэдлэг олгох чиглэлээр “Инновац, цахим бодлого”, “Үндэсний аюулгүй байдал, геополитик”, нийгмийн мэдрэмж олгох, хувь хүний хөгжлийг дэмжих хүрээнд “Хүний эрхэд суурилсан хандлага”, “Жендэрийн мэдрэмж”, “Эрүүл мэндийн боловсрол олгох” сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулав. Үүний үр дүнд

“Парламентын сургалтын цогц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх механизм бүрдэж, Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа шинэ шатанд гарч байна.

“Парламентын сургалтын цахим систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлж, хэвшүүлэх зорилгоор “Teachable” системд Төрийн эрх мэдлийн хуваарилалт ба хууль тогтоох байгууллага, Хүний эрх ба ардчилал, Бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээ, Онлайн оффис (google tools)-ийн хэрэглээ, жендэрийн хэвшмэл ойлголт зэрэг 12 сургалтыг байршууллаа.

Ингэснээр Тамгын газрын албан хаагчдад зориулсан сургалтыг ажлын байрны онцлог, орчин үеийн шаардлагад нийцүүлэн цахим хэлбэрээр, хүртээмжтэйгээр зохион байгуулах нөхцөл бүрдэж, ажилтнууд тодорхой сэдвийг сонгон судлах боломжтой болов.

### Парламентын судалгааны хүрээлэнгийн хамтын ажиллагаа



2021 онд Улсын Их Хурлын Тамгын газар Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, парламентын сургалтын хөтөлбөр, модулийг хамтран боловсруулах, хэрэгжүүлэх, хамтарсан сургалт зохион байгуулах, судалгаа хийх, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний



“Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалт

бүтээл, судалгааны тайлан, сургалтын хэрэглэгдэхүүн, судалгаа шинжилгээний ажилд шаардагдах мэдээлэл харилцан солилцох ажлуудыг эхлүүлэв.

Хүрээлэнгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, Швейцарын парламентын Тамгын газар болон төрийн болон олон улсын зарим байгууллагатай хамтран Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын албан хаагчдад зориулсан 10 удаагийн сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

АНУ-ын Азийн сантай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын ажилтнуудыг чадавхжуулах, “Парламентын боловсрол” хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх ажлыг хэрэгжүүлээ. Мөн энэ зорилгоор Фридрих Эбертийн сантай хамтран “Парламентын боловсрол” хөтөлбөрийн 4 төрлийн гарын авлага, хэрэглэгдэхүүнийг хэвлэж, олон нийтийн хүртээл болгосноор тус хөтөлбөрийг үндэсний хэмжээнд

түгээн дэлгэрүүлэх ажил эхэллээ.

Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Швейцарын парламентын Тамгын газрын туршлага судлах 5 удаагийн сургалт, болон Хүний эрхэд суурилсан хандлага сэдэвт танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан нь Тамгын газрын албан хаагчдын мэргэжлийн хөгжлийг дэмжиж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулав.

Түүнчлэн, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, АНУ-ын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын “Ардчиллын түншлэл” хөтөлбөртэй хамтран парламентын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагааны хүрээнд Улсын Их Хурлын гишүүдтэй мэдээлэл, туршлага солилцох 3 удаагийн уулзалтыг үр дүнтэй зохион байгуулав.



Улсын Их Хурлын Тамгын газар болон Швейцарын хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлэх төслийн гэрээнд гарын үсэг зурав.



Азийн сантай хамтран ажиллах Санамж бичиг, 2021 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.

### 5.3. Дүгнэлт, зорилт

#### Дүгнэлт

Тамгын газар 2021 онд Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдийн захиалга болон цаг үеийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 81 судалгааны ажил эрхлэн гүйцэтгэж, Улсын Их Хурлаас хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь судалгаа шинжилгээ, лавлагаа, мэдээллээр шуурхай хангаж ажиллалаа. Судалгааны ажлын тоо өмнөх оноос 40 хувиар өссөн байна.

Эдгээрээс цахим засаглал, тоон гарын үсгийн эрх зүйн зохицуулалт, олон улсын чиг хандлага, кибер аюулгүй байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага, нийтийн мэдээллийн ил тод байдал болон хүний хувийн мэдээлэл хамгаалах талаарх бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалт зэрэг сэдвээр 7 төрлийн судалгаа хийж, Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийг мэдээллээр хангаж ажилласнаар Монгол Улсад цахим хөгжлийн эрх зүйн орчныг цогцоор бий болгоход томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна.

“Парламентын судалгаа шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл, “Парламент” судалгааны эмхэтгэлийн 4 боть, “Мэдээлэл судалгаа” аналитик тойм мэдээллийн 25 цуврал эрхлэн гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг шинжлэх ухаанд суурилсан судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.

2021 онд дэвшүүлсэн зорилтынхоо дагуу “Парламентын сургалт”-ын 15 дэд хөтөлбөр, тэдгээрийн агуулгыг боловсруулж, “Сургалтын цахим систем”

бий болгосноор Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмж, чанарыг дээшлүүлж, сонгон суралцах боломж өргөжив.

Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын албан хаагчдад зориулсан нийт 48 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 2200 албан хаагчийг хамруулан, Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтоо хэрэгжүүлж ажиллалаа.

Номын санг цахимжуулах системийн шинэчлэл, хөгжүүлэлтийн ажил эхэлж, Номын баярыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж хэвшсэн нь иргэдэд ном унших дадал, соёлыг түгээх үр дүнтэй алхам боллоо.

Парламентын судалгааны хүрээлэнгийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааг Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн Ажлын алба, Тамгын газрын ажилтнуудыг оролцуулан анх удаа гүйцэтгэж, цаашид үйлчилгээний чанар, хүртээмж, судалгаа шинжилгээний бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх арга зам, баримтлах чиглэлээ тодорхойллоо.

Парламентын судалгааны хүрээлэнгийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн сан, Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн, ХБНГУ-ын Фридрих Эбертийн сантай хамтран Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын албан хаагчдад зориулсан хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулав.

**ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД  
ЧИГЛЭСЭН СУДАЛГАА, ЛАВЛАГААГААР ХАНГАХ.**

1. Баримт нотолгоонд суурилсан мэдээлэл, судалгаагаар Улсын Их Хурлын гишүүдийг тогтмол, шуурхай хангаж, Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомжийн чанар, үндэслэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
  - 1.1. Бодлогын судалгааны мэдээллийн нэгдсэн сан бий болгох зорилгоор Монгол Улсад бодлого судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг судалгааны байгууллагууд, номын сангууд болон төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох цахим сүлжээний эхлэлийг тавьж, портал системийн хөгжүүлэлтийг эхлүүлнэ.
  - 1.2. Парламентын судалгааны хүрээлэнгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ хэрэгжүүлнэ.
  - 1.3. Судалгааны цахим сан, хайлтын системийг хөгжүүлж, цахим уншлага хийх боломжийг бүрдүүлэн хэрэглэгчид судалгааны бүтээгдэхүүнтэй хялбар, түргэн шуурхай танилцах нөхцөлийг хангана.
2. Цахим эх сурвалжийг нэмэгдүүлж, Парламентын номын сангийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ.
  - 2.1. Парламентын номын сангийн бүртгэлийг шинэчилж, номын лавлагааг цахим хэлбэрээр шуурхай авах нөхцөл бүрдүүлнэ.
  - 2.2. Номын сангийн фондод байгаа үнэ цэнэтэй ховор ном, сониныг цахим хэлбэрт шилжүүлж, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулна.





## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

- 6.1 Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлээр үзүүлсэн туслалцаа
- 6.2 Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр үзүүлсэн туслалцаа
- 6.3 Гадаад харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, лавлагаа, мэдээ, танилцуулгаар хангах чиглэлээр хийсэн ажил
- 6.4 Дүгнэлт, зорилт



Дэлхийн улс орнуудад Коронавируст (КОВИД-19) цар тахлын онцгой нөхцөл байдал үргэлжилсэн цаг үед төрийн дээд хэмжээний гадаад, дотоод айлчлал, парламентын хоёр талт болон олон талт уулзалт, зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулснаар хууль тогтоох байгууллагуудын итгэлцлийг бэхжүүлж, уламжлалт найрсаг харилцааг үргэлжлүүлэн, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэв.

## VI БҮЛЭГ

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛД ҮЗҮҮЛСЭН МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАЛЦАА

“ Улсын Их Хурлын Тамгын газар 2021 онд Улсын Их Хурлын удирдлага, гишүүдэд гадаад бодлого, парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн, мэдээллээр хангаж, айлчлал, хурал, уулзалт, арга хэмжээг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан амжилттай зохион байгуулж ажиллав.

### 6.1. Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах чиглэлээр үзүүлсэн туслалцаа

Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэм, Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах хүрээнд гадаадад

3 айлчлал, дотоодод 8 айлчлал, бусад уулзалт болон цахим хуралдааныг зохион байгуулж ажиллав. Үүнд:

#### Гадаад айлчлалын хүрээнд:



#### Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчдийн АНУ-д хийсэн айлчлал

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 09 дүгээр сарын 16-наас 23-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-д айлчлал хийв. Улсын Их Хурлын даргын АНУ-д хийсэн энэхүү айлчлал нь талууд 2019 онд Стратегийн түншлэл тогтоосноос хойш зохион байгуулсан өндөр түвшний анхны айлчлал гэдгээрээ онцлог болов.

Айлчлалын хүрээнд болсон уулзалтуудын үеэр талууд Монгол-Америкийн Стратегийн түншлэлийг бататган бэхжүүлэх, хоёр талын хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх, ардчиллыг хамтдаа бэхжүүлэхийн төлөө тууштай байгаагаа харилцан илэрхийлсэн болно.

Мөн Монгол, Америкийн хооронд “Чөлөөт худалдааны хэлэлцээр” байгуулах тухай яриа хэлэлцээг эхлүүлэх асуудлыг хөндөж, эдийн засгийн харилцааг



идэвхжүүлэх, улмаар хамтын ажиллагааг мэдээллийн технологи болон соёлын салбарт өргөжүүлэх, шинэ боломжуудыг нээх, АНУ-ын Конгресст өргөн баригдаад буй Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хуулийг батлуулах явцыг урагшлуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр олон улсын түвшинд хамтран ажиллах зэрэг асуудлаар ярилцаж, ойлголцсон чухал ач холбогдолтой айлчлал болсон юм.



Бүгд Найрамдах Энэтхэг Улсад хийсэн айлчлал



### Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчдийн БНЭУ-д хийсэн айлчлал

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын Дэд ерөнхийлөгч бөгөөд Парламентын Ражяа Сабхагийн дарга Венкаая Наиду болон Лок Сабхагийн дарга Ом Бирла нарын урилгаар 2021 оны 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд БНЭУ-д айлчлал хийсэн нь Монгол Улсаас БНЭУ-д парламентын даргын түвшинд 11 жилийн дараа хийсэн айлчлал болов.

Манай улсын гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Монгол, Энэтхэгийн Стратегийн түншлэлийн харилцааг

гүнзгийрүүлэн хөгжүүлэх, өндөр дээд түвшний яриа хэлэлцээг тогтмолжуулах, хууль тогтоох байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, соёл, урлаг, соёлын бүтээлч үйлдвэрлэл, мэдээллийн технологийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёр улсын харилцааны бэлгэ тэмдэг болсон Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Монгол Улсаас Энэтхэг Улсад экспортлох коксжих нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр ложистикийн асуудлыг урагшлуулахад түлхэц үзүүлсэн нь айлчлалын гол үр дүн байв.





## Монгол Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан тэргүүтэй төлөөлөгчдийн БНПУ-д хийсэн айлчлал



Бүгд Найрамдах Польш Улсад хийсэн айлчлал

Монгол Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан Бүгд Найрамдах Польш Улс (БНПУ)-ын Сеймийн дэд маршал

М.Гошевскагийн урилгаар 2021 оны 11 дүгээр сарын 07-ноос 11-ний өдрүүдэд БНПУ-д айлчлал хийв. Айлчлалын үеэр Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан БНПУ-ын Сеймийн дэд маршал Малгожата Гошевска, Сенатын дэд маршал Богдан Борусевич, Польш-Монголын парламентын бүлгийн дарга Марек Жонса болон бүлгийн гишүүд, Польшийн зэсийн “КГХМ” компанийн дэд дарга Павел Груза болон албаны бусад хүмүүстэй уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар дэлгэрэнгүй ярилцаж, санал солилцсон нь хоёр улсын харилцааг улс төр, худалдаа, эдийн засаг, геологи, уул уурхай, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой болов.

## Дотоод арга хэмжээний хүрээнд:



## Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын Хорооны дарга Ли Жанышү нарын цахим уулзалт

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Байнгын хорооны дарга Ли Жанышүтай цахим уулзалт хийв.

Энэхүү дээд хэмжээний цахим уулзалтаар талууд хоёр улсын хууль тогтоох байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хоёр талын өндөр дээд хэмжээний харилцан айлчлал, туршлага солилцох арга хэмжээг тогтмолжуулах, хоёр улсын Засгийн газар хоорондын “Талын зам” болон “Бүс ба Зам” санаачилгын бүтээн байгуулалтыг урагшлуулах чиглэлээр харилцан санал солилцсон.

Түүнчлэн, “КОВИД-19” цар тахалтай тэмцэхэд нягт хамтран ажиллах, ялангуяа дэлхий нийтээр эрэлт ихтэй байгаа вакциныг манай улсад буцалтгүй тусламжаар нийлүүлэх, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлэх тал дээр харилцан байр сууриа илэрхийлсэн юм.





## Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал хоорондын байнгын уулзалтын механизмын 4 дэх удаагийн уулзалт

Монгол Улсын Их Хурал, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал хоорондын байнгын уулзалтын механизмын 4 дэх удаагийн уулзалт 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр цахимаар зохион байгуулагдав. Уулзалтыг Монголын талаас Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурал дахь Монгол-Хятадын парламентын бүлгийн дарга Т.Аюурсайхан, Хятадын талаас БХАТИХ-ын Байнгын хорооны дэд дарга, Хятад-Монголын парламентын бүлгийн дарга Байма Чилинь нар даргалав.

Уг уулзалтаар хоёр улсын харилцаа, парламентын хамтын ажиллагаа, Засаглалын туршлага хуваалцах, Цар тахлын эсрэг хамтын ажиллагаа болон Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэсэн 4 үндсэн сэдвээр өрнөв.

Монгол, Хятадын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, хоёр орны парламент хоорондын хамтын ажиллагааг улам идэвхжүүлэх, цар тахлын нөхцөл байдалд хэвийн явуулах боломжуудыг эрэлхийлэх, хоёр улсын парламентын зүгээс өөрийн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тогтвортой урагшлуулахад шаардлагатай эрх зүйн үндсийг бүрдүүлэх зэрэг асуудлуудаар санал солилцож, тодорхой ойлголцолд хүрсэн.



## ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.И.Косачёв тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал

Монгол Улс, Оросын Холбооны Улс (ОХУ)-ын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 100 жилийн ой 2021 онд тохиосон. ОХУ нь манай улстай дипломат харилцаа тогтоосон анхны улс бөгөөд талууд тэгш ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган, амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Тэмдэглэлт ойг тохиолдуулан ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.И.Косачёв тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 11 дүгээр сарын 04-нөөс 07-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ нартай уулзалт хийв.

Уулзалтуудын үеэр талууд Монгол Улс, ОХУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн хамтын ажиллагааг харилцан сонирхсон

бүхий л салбарт өргөжүүлэн бэхжүүлэх, тэр дундаа хоёр улсын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хууль тогтоох байгууллагууд хоорондын механизм байгуулах, хоёр орны болон олон талт оролцоогоор хамтран хэрэгжүүлж буй төслүүдэд дэмжлэг үзүүлж, урагшлуулах зэрэг асуудлаар санал солилцсон билээ.



ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.И.Косачёв тэргүүтэй төлөөлөгчид



**Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн Гадаад хамтын ажиллагааны хороо хоорондын цахим уулзалт**

Дипломат харилцааны 100 жилийн ойн хүрээнд “Монгол-Орос” найрамдлын нийгэмлэг, Улаанбаатар хот дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төвтэй хамтран “100 жилийн турш хамтдаа” сэдэвт цуврал буухиа уулзалтыг зохион байгуулав.

Хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой уулзалтаар улс төр, зам тээвэр, хүнс, хөдөө аж ахуй, соёл, боловсрол болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагаа, цаашдын зорилтын талаар санал солилцсон юм.

Дипломат харилцааны 100 жилийн ойн тэмдэглэх хүрээнд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн Гадаад хамтын ажиллагааны хороо хоорондын цахим уулзалтыг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Тус цахим уулзалтаар парламент хоорондын харилцаа, хүмүүнлэгийн хамтын ажиллагааны хөгжлийн талаар харилцан ярилцаж, мэдээлэл солилцов.



“100 жилийн турш хамтдаа” сэдэвт цуврал буухиа уулзалт



**Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд маршал Малгожата Гошевска тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал**

Монгол, Польшийн хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 70 жилийн ойн хүрээнд 2021 онд хоёр улсын парламентын дэд дарга нар харилцан айлчилсан нь хоёр улсын хууль тогтоох байгууллагуудын уламжлалт найрсаг харилцааг улам бүр гүнзгийрүүлэх, харилцааны олон чухал асуудлуудыг урагшлуулахад чухал түлхэц үзүүлсэн үзүүлсэн болно.

2021 онд Улаанбаатар хотод БНПУ-ын элчин сайдын яам дахин нээгдсэн бөгөөд элчин сайдын яамны дэргэд Консулын хэлтсийг нээж, Польш Улсын визийг Улаанбаатар хотоос олгох асуудлыг шийдвэрлэх, хоёр талын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, ингэхдээ Монгол Улсын экспортыг дэмжиж, худалдааны тэнцлийг хангахад анхаарах, геологи, уул уурхай, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зэрэг асуудлуудаар талууд хэлэлцэж тохирсон нь хоёр улсын харилцааны хөгжилд чухал ач холбогдолтой боллоо.



Айлчлалын үеэр

Монгол Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайханы урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд маршал Малгожата Гошевска тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 11 дүгээр сарын 22-ноос 25-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлал хийсэн.



**Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын Дэд ерөнхийлөгч Этторэ Розато тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал**

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Италийн парламентын бүлгийн дарга Б.Пүрэвдоржийн урилгаар Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын Дэд ерөнхийлөгч Этторэ Розато тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 10 дугаар сарын 12-ноос 17-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав.

Айлчлалын үеэр Дэд ерөнхийлөгч Этторэ Розато Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхав.

Дээрх уулзалтуудын үеэр талууд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар өргөжүүлэн хөгжүүлэхэд хүчин чармайлт гаргахаа онцлон тэмдэглэсэн юм.



*Бүгд Найрамдах Итали Улсын парламентын Төлөөлөгчдийн танхимын Дэд ерөнхийлөгч Этторэ Розато тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад хийсэн айлчлалынхаа үеэр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхав.*



**Бүгд Найрамдах Франц Улсын Сенат дахь Франц-Монголын парламентын бүлгийн дарга Филипп Мүэй тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал**

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Францын парламентын бүлгийн дарга Ж.Чинбүрэнгийн урилгаар Бүгд Найрамдах Франц Улсын Сенат дахь Франц-Монголын парламентын бүлгийн дарга Филипп Мүэй тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 09 дүгээр сарын 10-наас 16-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав. Айлчлалын хугацаанд төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхаж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.



*Франц-Монголын парламентын бүлгийн дарга нар хэвлэлийнхэнд зориулан мэдээлэл хийв.*



## 6.2. Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр үзүүлсэн туслалцаа



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид “Парламентын тэргүүн нарын дэлхийн V бага хурал”-д оролцов.

Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд олон улс, бүс нутгийн хурал, чуулга уулзалт, арга хэмжээнд Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийг

биечлэн болон цахимаар оролцуулах ажлыг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид 2021 оны 09 дүгээр сарын 04-нөөс 09-ний өдрүүдэд Австри Улсын Вена хотноо болсон “Парламентын тэргүүн нарын дэлхийн V бага хурал”-д оролцов. Олон Улсын Парламентын Холбооноос Австрийн парламент болон НҮБ-тай хамтран зохион байгуулсан уг бага хуралд 115 улсын парламентын төлөөлөгчид, түүний дотор 100 гаруй парламентын дарга, олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын тэргүүн нар оролцсон юм.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар бага хурлын үеэр “Парламентуудын нээлттэй, ил тод байдал ба аюулгүй байдал: Тэдгээрийг тэнцвэртэй хангах нь”, “КОВИД-19 цар тахлын эсрэг дэлхий нийтийн хариу арга хэмжээ нь олон талт хамтын ажиллагааны механизм бүх нийтийн төлөө үр дүн гаргах эсэх чадавхыг сорьж буй нь” сэдэвт хэлэлцүүлэгт тус тус оролцож үг хэлэв.

“ Улсын Их Хурлын дарга Дэлхийн парламентын тэргүүн нарын хуралд өөрийн биеэр оролцсон нь олон улсын талбарт Монгол Улсын байр суурийг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлснээс гадна улс орнуудын парламентын удирдлагууд биечлэн уулзах, хоёр талын харилцааны асуудлаар нүүр тулан ярилцах, улмаар улс орнуудын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэх зорилгод чухал алхам болсон юм.





**Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар олон улс, бүс нутгийн дараах хурал, уулзалтад цахимаар оролцоход техник, зохион байгуулалтыг хангаж ажиллав.**



МУИС, Азийн сан, Бүгд Найрамдахчуудын Олон улсын хүрээлэн, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон Стэнфордын их сургуулиас хамтран 2021 оны 01 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ази болон Монгол Улс дахь ардчиллын сорилт: Зөвлөлдөх ардчилал, онлайн парламент, сонгуулийн шинэчлэлээр дамжуулан инновац хийх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний цахим хурал.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын форумын ээлжит бус цахим уулзалт.



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 2008 оноос эхлэн жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг Олон улсын ардчиллын өдрийг тохиолдуулан Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Лок Сабхагаас “Үр дүнтэй, утга учиртай ардчиллыг дэмжихэд хууль тогтоох байгууллагуудын үүрэг оролцоо” сэдвийн дор зохион байгуулсан цахим хурал.



НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон Монгол Улс хамтран 2021 оны 11 дүгээр сарын 22-ноос 25-ны өдрүүдэд зохион байгуулсан Ази, Номхон далайн орнуудын Хөдөө аж ахуйн статистикчдын 29 дэх удаагийн хурал.



Бүгд Найрамдах Турк Улсын “Мармара Групп” сангаас “Коронавирусийн дараах шинэ дэлхий” үндсэн сэдвийн хүрээнд 2021 оны 07 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулсан Евразийн эдийн засгийн дээд хэмжээний 24 дүгээр цахим уулзалт.



Камбожийн Хаант Улсаас 2021 оны 11 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд “Хамтын өсөлтийн төлөө олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдвийн дор зохион байгуулсан Ази-Европын Дээд хэмжээний 13 дугаар цахим уулзалт (АСЕМ).

## Улсын Их Хурлын гишүүдийн оролцсон гадаад арга хэмжээ

Улсын Их Хурлын гишүүд Олон Улсын Парламентын Холбоо, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблей, Ази, Номхон далайн орнуудын парламентын чуулган, Азийн Парламентын Ассамблей зэрэг олон улс, бүс нутгийн парламентын байгууллагуудын ээлжит хурал, уулзалтад биечлэн болон цахим

хэлбэрээр оролцож, улс төр, энх тайван, аюулгүй байдал, эдийн засаг, жендэр, ардчилал, хүний эрх, тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг дэлхий нийтийн эрх ашгийг хөндсөн олон чухал сэдвүүдээр бусад улс орнуудын парламентчидтай харилцан туршлага солилцох, байр сууриа илэрхийлэх, гарц шийдэл эрэлхийлэх зэргээр хамтран ажиллав.

## Олон Улсын Парламентын Холбооны Ассамблейн 142 дугаар чуулган

ОУПХ нь дэлхийн улс орнуудын парламентуудыг эгнээндээ нэгтгэсэн хамгийн том байгууллага бөгөөд Улсын Их Хурлын төлөөлөгчид жил бүр үйл ажиллагаанд нь тогтмол оролцож ирсэн уламжлалтай. 2021 онд тус холбооны 142 дугаар Ассамблей бүхэлдээ цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бол 143 дугаар Ассамблейг Испани Улсын парламентаас Мадрид хотноо биечлэн оролцох хэлбэрээр зохион байгуулсан.

ОУПХ-ны 142 дугаар Ассамблей, Байнгын хороодын болон салбар хуралдаанууд 2021 оны 04 дүгээр сарын 26-наас 05 дугаар сарын 28-ны өдрүүдэд “Цар тахлыг өнөөдөр даван туулж, сайн

сайхан маргаашийг цогцлоох нь: Парламентуудын үүрэг” үндсэн сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж, Ассамблейн нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж, мэндчилгээ дэвшүүлэв.

ОУПХ-ны 142 дугаар Ассамблей болон бусад хуралдаанууд Ковид-19 цар тахлын онцгой нөхцөлд анх удаа бүрэн цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулагдаж, дэлхийн улс орнуудын парламентын удирдлага, гишүүд Ассамблейн үндсэн сэдвээр мэтгэлцэж, өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлэн санал бодлоо хуваалцав.

## Олон Улсын Парламентын Холбооны Ассамблейн 143 дугаар чуулган

ОУПХ-ны ээлжит 143 дугаар Ассамблей “Ардчиллын орчин үеийн сорилтууд: Нийгмийн хуваагдлыг даван туулж бэхжүүлэх нь” үндсэн сэдвийн дор 2021 оны 11 дүгээр сарын 25-наас 30-ны өдрүүдэд Испанийн Хаант Улсын Мадрид хотноо зохион байгуулагдсан ба Монголын парламентыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан нар оролцож, Ассамблейн нэгдсэн хэлэлцүүлэг, салбар хуралдаан болон байнгын хорооны хуралдаануудад үг хэлж, бусад орны парламентын төлөөлөгчидтэй хоёр улсын харилцаа, хууль тогтоох байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцов.



Олон Улсын Парламентын Холбооны Ассамблейн 143 дугаар чуулганд Улсын Их Хурлын гишүүд оролцов.

Түүнчлэн, 2021 онд цахим хэлбэрээр зохион байгуулагдсан ОУПХ-ны Цахим парламентын олон улсын 9 дүгээр бага хурал, Дэлхийн худалдааны байгууллага болон Сингапур Улсын Ражаратнам олон улс судлалын сургуулиас зохион байгуулсан Олон улсын худалдааны асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын семинар болон АНУ-ын Конгрессийн Төлөөлөгчдийн танхимын дэргэдэх Ардчиллын түншлэл байгууллагаас зохион байгуулсан “Хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх засаглалд тавих хяналт шалгалтыг сайжруулах нь” сэдэвт хэлэлцүүлэг, Азийн Парламентын Ассамблейн Эдийн засаг, тогтвортой хөгжлийн байнгын хороо, Нийгэм, соёлын байнгын хороо, Төсөв, төлөвлөлтийн байнгын хорооны цахим хурал, ОУПХ-ноос Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран зохион байгуулсан ДОХ/ХДХВ-ийн асуудлаарх НҮБ-ын дээд хэмжээний уулзалт болон Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын форумаас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран “Дэлхий нийтийн эрүүл мэнд ба КОВИД-19 Ази-Номхон далайн парламентын форум” сэдэвт дөрөв дэх удаагийн цахим уулзалт, ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн ээлжит чуулганы нэгдсэн болон хороодын хуралдаан, БНСУ-ын Үндэсний Ассамблейгаас зохион байгуулсан Ази, Номхон далайн орнуудын парламентын чуулганы 29 дүгээр цахим уулзалтад Улсын Их Хурлын гишүүд идэвхтэй оролцож, тухайн сэдвийн хүрээнд үг хэлж, байр сууриа илэрхийлэв.

Ковид-19 цар тахлын цаг үед олон улс, бүс нутгийн байгууллагын хурал, чуулганд Улсын Их Хурлын удирдлага,

гишүүд хосолмол хэлбэрээр оролцсон нь олон талт харилцааг тасралтгүй үргэлжлүүлэх, тухайн асуудлаар манай улсын төр, засгаас авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг мэдээлэх, бусад улс орнуудтай хамтран ажиллаж, туршлага, мэдээлэл солилцоход үр дүнтэй арга хэрэгсэл болов.



*Цахим хэлбэрээр зохион байгуулагдсан Олон Улсын Парламентын Холбооны хурал, уулзалтуудад Улсын Их Хурлын гишүүд оролцов.*

2021 онд Улсын Их Хурал дахь парламентын бүлгийн дарга нар холбогдох улсын парламент дахь Монгол Улстай харилцах найрамдлын бүлгийн дарга, гишүүдтэй цахим уулзалтууд хийж, хоёр талын харилцаа, түүний дотор хууль тогтоох байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар ярилцаж, санал солилцсон нь парламент хоорондын харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, үүгээр дамжуулан хоёр талын харилцааны асуудлуудыг урагшлуулахад улс төрийн дэмжлэг үзүүлж, нааштайгаар шийдвэрлэхэд түлхэц боллоо.

## Улсын Их Хурлын Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

ОУПХ-ны дэргэдэх Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгээс “Парламентууд цар тахлын нөхцөл байдалд дасан зохицож ажиллах нь” сэдвийн хүрээнд 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан оролцов. Уулзалтаар 2021 онд Ковид-19 цар тахал парламентуудад олон сорилт бэрхшээл үүсгэж байгааг онцлоод, дэлхийн улс орнуудын парламентууд цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж байгаа хариу арга хэмжээний тухай илтгэлүүд хэлэлцүүлэв.

ОУПХ-ны 142 дугаар Ассамблейн үеэр болсон Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн цахим хуралд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан оролцож, “Цар тахлын үеэрх парламентуудын үүрэг, зохион байгуулалт” сэдэвт 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралд илтгэл илгээн, цар тахлын сөрөг нөлөөллийг эрсдэл багатай даван туулах, цар тахлын дараах сэргээлтийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаарх туршлагаа хуваалцав.

Түүнчлэн 2021 оны 11 дүгээр сарын 28-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулсан ОУПХ-ны дэргэдэх Парламентуудын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хуралд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан оролцсон бөгөөд тус нийгэмлэгийн 70 гаруй гишүүн орнуудын төлөөлөгчид “Хууль тогтоох үйл ажиллагаанд парламентын хороодын гүйцэтгэх үүрэг, хамаарал” үндсэн сэдвийн дор хуралдаж, харилцан туршлага солилцов.

Парламентын хууль тогтоох үйл ажиллагаа, хяналтын механизмыг бэхжүүлэх, хууль тогтоох үйл ажиллагааг сурталчлан, олон нийтийн оролцоог хангах, парламентын Тамгын газруудын үйл ажиллагааг сайжруулахад анхаарах зүйлс, үүний дотор албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх, парламентын цахим шилжилттэй холбоотой асуудлуудаар хэлэлцүүлэг өрнөлөө.

Тус хурлын үеэр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан ХБНГУ-ын Бундестагийн Тамгын газрын дарга Др.Лоренц Мюллертэй уулзалт хийж, хоёр улсын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцов.

## Олон Улсын Парламентын Холбооны дэргэдэх Парламентуудын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хурал



ОУПХ-ны дэргэдэх Парламентуудын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хурал

### 6.3. Гадаад харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, лавлагаа, мэдээ, танилцуулгаар хангах чиглэлээр хийсэн ажил

Гадаад бодлого, парламент хоорондын харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, лавлагаа, мэдээллээр хангах хүрээнд баримт бичиг боловсруулах, орчуулах,

уулзалт зохион байгуулах, хэлмэрчлэх, шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэв.

Улсын Их Хурлын Тамгын газар болон Швейцарын Холбооны Улсын парламентын Тамгын газар хооронд “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төсөл, Улсын Их Хурлын Тамгын газар болон Азийн сангийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг болон тэдгээрийн 2021 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, үйл ажиллагаа нь эхлэв.



Улсын Их Хурлын даргаас гадаад улсын парламентын дарга нарт 74 илгээлт, захидал, Улсын Их Хурлын дэд дарга, гишүүдээс гадаад улсын парламентын дэд дарга, гишүүд, Олон улсын байгууллагын тэргүүн нарт 33 захидал, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагаас гадаад харилцаа, арга хэмжээтэй холбоотой 20 захидал, албан бичиг, Гадаад харилцааны хэлтсээс 72 албан бичиг, 92 цахим шууданг Гадаад харилцааны яам, Элчин сайдын яамд болон холбогдох бусад байгууллага, газарт хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын хороодын дарга нар болон Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайд нар болон Олон улсын байгууллагын тэргүүн нартай биечлэн болон цахимаар хийсэн 79 уулзалтыг зохион байгуулав.



Улсын Их Хурлын даргаас гадаад улсын парламентын дарга, Улаанбаатар дахь Дипломат төлөөлөгчийн газрууд болон Олон улсын байгууллагуудын тэргүүн нарт илгээсэн 207, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаас бусад улс орнуудын парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга болон холбогдох хүмүүст илгээсэн 94 мэндчилгээг цахимаар хүргүүлэв.

Улсын Их Хурал дахь Байгаль хамгаалах консервацийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, Олон улсын байгаль хамгаалах сантай хамтран ажиллах санамж бичиг байгуулах үйл ажиллагааг эхлүүлэв. Улсын Их Хурлын даргын санаачилгаар Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка)-тай хамтран “Япон лугаа адил хөгжье” уриалгын хүрээнд цуврал лекц, хэлэлцүүлгийг хийж, дээрх байгууллагуудтай техникийн хамтын ажиллагаа өрнүүлж, улмаар Улсын Их Хурлын чадавхыг институцийн болон хүний нөөцийн түвшинд хөгжүүлэх шинэ эхлэлийг тавив.



Улсын Их Хурал болон Тамгын газрын удирдлагад ирүүлсэн захидал болон бусад баримт бичгүүдийг орчуулж, танилцуулан, хариу бичгийн төсөл боловсруулж, албажуулан хүргүүлэв.

## 5.3. Дүгнэлт, зорилт

### Дүгнэлт

Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг Коронавируст цар тахлын үеийн нөхцөл байдалд зохицуулан зохион байгуулснаар олон улс, бүс нутгийн байгууллагуудын ээлжит хурал, чуулган, хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын дарга, гишүүд, Тамгын газрын удирдлага биечлэн болон цахимаар оролцож, олон талт хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж чадлаа.

Дэлхийн улс орнуудын парламентын төлөөлөгчидтэй хоёр талын уулзалтуудыг амжилттай зохион байгуулсан нь хууль тогтоох байгууллагууд хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, уламжлалт найрсаг харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болов.

Улсын Их Хурлын даргын АНУ, БНЭУ-д, дэд даргын БНПУ-д хийсэн айлчлал, ОХУ, БНПУ, БНИУ, БНФУ-ын парламентын төлөөлөгчдийн Монгол Улсад айлчилсан айлчлал, БНХАУ, ОХУ-ын парламентын удирдлага, Байнгын хороодын дарга нарын дээд хэмжээний цахим уулзалтуудыг зохион байгуулав.

Улсын Их Хурал дахь парламентын бүлгэмийн дарга, гишүүд өөрсдийн санаачилгаар дэлхийн улс орнуудын парламентын гишүүд, Элчин сайд нартай биечлэн болон цахимаар уулзаж, хоёр улсын харилцааны өнөөгийн тулгамдсан болон цаг үеийн бусад асуудлаар ярилцаж, тодорхой санал, санаачилга дэвшүүлж ажиллалаа.

### 2022 оны зорилт

#### ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ

1. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг Олон Улсын Парламентын Холбоо болон ижил түвшний байгууллагуудтай өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - 1.1. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн зорилтыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
  - 1.2. Олон Улсын Парламентын Холбоо, түүний дэргэдэх Хүний эрх, жендэрийн хөтөлбөр болон Инновацын төвтэй шинэ хамтын ажиллагааг эхлүүлнэ.
  - 1.3. Улсын Их Хурлын Тамгын газраас гадаад орнуудын парламентын Тамгын газартай тогтоосон найрсаг харилцааг идэвхжүүлэн хөгжүүлж, хамтын ажиллагааны шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  - 1.4. Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлийг тэргүүлэх зорилт болгон Тамгын газрын албан хаагчдыг гадаад улсад туршлага судлах, дадлагажих хөтөлбөрт хамруулах, олон улс, бүс нутгийн хурал, семинарт оролцуулахад дэмжлэг үзүүлнэ.

## ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА

- 7.1. Захиргаа, хүний нөөцийн удирдлага
- 7.2. Албан хэрэг хөтлөлт, архив
- 7.3. Санхүүгийн удирдлага, дотоод аудит
- 7.4. Дүгнэлт, зорилт



“Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, албан хаагчдын хувь хүний болон гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх бодлогыг тодорхойлов.

## VII БҮЛЭГ

# ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА

### 7.1. Захиргаа, хүний нөөцийн удирдлага (Бодлого төлөвлөлт, дүрэм журмын шинэчлэл)

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 295 дугаар захирамжаар баталсан “Улсын Их Хурлын Тамгын газрын 2020-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд 51 зорилт, 299 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 51 зорилт, 299 арга хэмжээ, нэмэлт 29 арга хэмжээ, нийт 328 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр

Тамгын газарт өгсөн “Хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох дүрэм журмыг шинэчлэн батлах” чиглэлийн дагуу нийт 19 журмыг шинэчлэн баталж, мөрдөж байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй нийт 95 дүрэм, журам, зааврыг нэгдсэн санд бүртгэн, Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP) болон Cloud.parliament.mn цахим сүлжээнд байршуулж, тухай бүр шинэчлэн, албан хаагчдыг шаардлагатай хууль тогтоомжийн талаарх мэдээллээр шуурхай хангаж ажиллав.

“” 2021 онд нийт дүрэм, журам, зааврын 20 хувийг Монгол Улсын Их Хурлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж батлууллаа.

Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын судалгаа





Ингэснээр Тамгын газрын үйл ажиллагааг зохицуулж байгаа дотоод эрх зүйн орчныг шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж, Монгол Улсын Их Хурлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангаж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах хуульд

заасан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах нөхцөл бүрдэв.

2022 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой болон Тамгын газрын цахим шилжилт, судалгаа шинжилгээний ажлыг нарийвчлан зохицуулсан 26 дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.



### Хүний нөөцийн удирдлага, нийгмийн баталгаа

2021 онд Тамгын газар 201, Улсын Их Хурлын гишүүний ажлын алба 292, Улсын Их Хурлын даргын ажлын алба 22 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэв.

Тайлант хугацаанд Тамгын газрын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллалаа.

Энэ хүрээнд Тамгын газрын Стратеги төлөвлөгөөний 3.7.1-д заасан “Парламентын ажлын мэргэшсэн албаны

бодлого, эрх зүй, эдийн засгийн баталгаа, тогтолцоог бүрдүүлэх, чадварлаг хүний нөөцийг хангах” зорилтын хүрээнд Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн баталж, 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх зэрэг хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох хууль тогтоомж, хүний нөөцийн судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан тасралтгүй, шуурхай, үр дүнтэй зохион байгуулж ажиллав.

## Хүний нөөцийн судалгаа, мэдээлэл

2021 онд ажил, албан тушаалд шинээр томилогдсон 33, албан тушаалаас чөлөөлөгдсөн 27, дэвшин ажилласан 1, шилжин болон үргэлжлүүлэн ажилласан 17 албан хаагч байгаа бөгөөд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд

нийцүүлэн албан хаагчдын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг хийв.


Хүний нөөцийн хөдөлгөөн, чадавхыг нас, хүйс, мэргэжил, боловсрол, ажилласан жилийн үзүүлэлтээр дараах байдлаар харуулав.

### Хүний нөөцийн хөдөлгөөн:




“” Тамгын газрын хүний нөөцийн төлөвлөлт, шилжилт хөдөлгөөнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тасралтгүй, шуурхай зохион байгуулснаар Улсын Их Хуралд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэх, мэргэшсэн албан хаагчдаар хүний нөөцийг бүрдүүлэх зорилт хэрэгжлээ.


### Насны ангилал



### Албан хаагчдын улсад ажилласан жил (2021)



### Хүйсийн харьцаа (2021)



### Боловсролын зэрэг, цол



Тамгын газрын нийт албан хаагчдын 27.9 хувь нь 10 хүртэл жил, 20.9 хувь нь 11-15 жил, 30.9 хувь нь улсад 21 ба түүнээс дээш жил ажиллаж буй албан хаагчид байна. Дээрх судалгаанаас үзвэл 72.1 хувь нь улсад 11 ба түүнээс дээш жил, түүний

дотор 30.9 хувь буюу 3 албан хаагч тутмын нэг нь 21 ба түүнээс дээш жилийн ажлын туршлагатай байна. Энэ нь Тамгын газрын мэргэшсэн ажилтны нөөц өндөр түвшинд байгааг харуулж байна.

### Мэргэжлийн байдал:



### Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн батлав.

Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний 6.1.5-д заасан “Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 828 дугаар захирамжаар “Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, албан хаагчдын оролцоонд суурилсан, хувь хүний болон гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой,

бүтээмжтэй ажиллах зорилтын хүрээнд 41 арга хэмжээг 4 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр албан хаагчид эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүрдэж, хуульд заасан нийгмийн баталгаагаар хангагдаж, хувь хүний хөгжлийн болон мэргэшлийн ур чадвар, бүтээмж дээшилж, төрийн албаны ёс зүйг баримтлан, ажлын байрны хамтач, эрүүл уур амьсгал, харилцааны эерэг хандлагыг бүрдүүлэн, дадлага, туршлагатай, мэргэшсэн хамт олон бүрдэнэ гэж үзэж байна.

### Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийг шинэчлэв.

Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд суурин болон зөөврийн компьютер, олон үйлдэлт принтер, ухаалаг самбар, өндөр хурдны скайнер, хувилах машин, бусад техник хэрэгсэлийг шинээр худалдан авч, 278 албан хаагч (давхардсан тоогоор)-ийн техник, хэрэгслийг шинэчилж, 390 ам.метр талбай бүхий 16 өрөө, танхимын засвар, үйлчилгээг хийж,

албан хаагчдын бүтээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүллээ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг цахимаар болон “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд албан ёсоор бүрэн эхээр хэвлэн нийтэлж олон нийтэд хүргэх чиг үүргийн хүрээнд албан ёсны эх сурвалжаар хангах үйл ажиллагааг цаг хугацаанд нь гүйцэтгэв.

## Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах бусад арга хэмжээ

Тамгын газрын албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд 2021 онд шаардлага хангасан 28 албан хаагчийг 6 хувийн хүүтэй орон сууцны зээлд хамруулан, 12 албан хаагчид холбогдох журамд заасан орон сууцны дэмжлэг үзүүлсэн нь албан хаагчдын

амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн үр дүнтэй ажил боллоо.

Мөн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу гэр бүлийн гишүүнээ асран тэтгэх болон гачигдал тохиолдсон 73 албан хаагчид дэмжлэг үзүүлж, 13 албан хаагчид өвлийн түлш худалдан авахад нь туслалцаа үзүүлэв.



Төрийн одон, медалиар шагнагдсан Тамгын газрын албан хаагчид

## Төрийн дээд одон медаль, бусад шагналаар шагнагдагсдын тоо




**1**  
Гавьяат



**11**  
Алтан гадас одон



**3**  
Монгол Улсын Их Хурлын даргын өргөмжлөл



**1**  
Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон



**15**  
Хөдөлмөрийн хүндэт медаль



**3**  
Тамгын газрын “Хүндэт өргөмжлөл”



**7**  
Салбарын шагнал

## Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулав.



Улсын Их Хурлын Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн гишүүд

Тамгын газрын нийт ажилтны хурлыг цахимаар зохион байгуулж, Ёс зүйн зөвлөлийн 7 гишүүнийг нээлттэйгээр сонгож, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 849 дүгээр захирамжаар Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийг байгуулав. Ёс зүйн зөвлөлд Тамгын газрын Удирдлагын зөвлөлийн гишүүдээс 2, тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах 1, эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах 1, ахлах түшмэлийн ангилалд хамаарах 2, төрийн үйлчилгээний албан тушаалд хамаарах 1 албан хаагчийг нийт ажилтнууд дундаас илээр санал хурааж сонгов.

Ёс зүйн зөвлөл нь Тамгын газрын хэмжээнд Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг сахиулах, ёс зүйн сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Тамгын газрын ажилтны ёс зүйн дүрмийг орчин үеийн парламентын ажлын албаны нийтлэг зарчим, үнэт зүйлс, хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай

хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Олон улсын парламентын холбооны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Европын парламентын албан хаагчийн ёс зүйн дүрэм зэрэг ижил төстэй баримт бичгийг харьцуулан судалж, "Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм", "Тамгын газрын албан хаагчийн ёс зүйн сургалтын хөтөлбөр"-ийн төслийг боловсруулаад байна.

Дээрх ёс зүйн дүрмийг батлан мөрдөж, сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулснаар Тамгын газрын албан хаагчдад ёс зүй, ёс суртахууны талаарх ойлголт, парламентын албан хаагчийн ёс зүйн онцлог, Олон улсын парламентын холбоо, Европын парламент болон гадаад улсуудын парламентын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, нийтлэг зарчмуудын талаарх мэдлэг эзэмших, ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх дадал, чадвар олж авах, мэргэшсэн ёс зүйтэй төрийн алба төлөвших нөхцөл бүрдэх юм.

## Цар тахлын үеийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ



2021 онд Коронавирус (КОВИД-19) цар тахлын тархалт хэвээр үргэлжилж, Тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад сорилт тулгарсан жил байлаа.

Уг сорилтыг даван туулахын тулд ажлын байрны өрөө, тасалгааг тогтмол ариутгаж,

халдваргүйжүүлэх, албан хаагчдыг зайнаас онлайнаар ажиллуулах, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлаа сэргээх багцыг нийт албан хаагчдад олгох, Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг эмнэлэг болон ажлын байран дээр зохион байгуулах, халдварын тохиолдлыг илрүүлэх шинжилгээг тогтмол зохион байгуулах зэрэг арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлж ажиллалаа.

Тухайлбал, нийт албан хаагчдад дархлаа сэргээх, халдвараас хамгаалах багц бүтээгдэхүүнийг 2 удаа олгож, давхардсан тоогоор 544 албан хаагчийг Коронавирусийн эсрэг дархлаа тогтоох вакцины 1, 2, 3-р тунд хамруулах ажлыг зохион байгуулав.


Эдгээр арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлсэн нь Улсын Их Хурал, Тамгын газар үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болов.

“ “ **Коронавирусийн эсрэг вакцины 1, 2-р тунд нийт албан хаагчид бүрэн, 3-р тунд 85 хувь хамрагдсан байна.**

## 7.2. Албан хэрэг хөтлөлт, архив

2021 онд баримт бичиг зохион бүрдүүлэхээс бусад албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, Улсын Их Хурал, түүний

Тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэн баталж, бичиг хэргийн эргэлтэд тогтмол хяналт тавих механизмыг бий болгов.



Тайлант хугацаанд Улсын Их Хуралд 5060, Тамгын газарт 6669 албан бичиг ирснийг бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, долоо хоног, сар бүр тогтмол тайлан мэдээ гаргаж, бичиг хэргийн эргэлтэд хяналт тавьж ажиллалаа.

Өмнөх онтой харьцуулахад 2021 онд Улсын Их Хуралд ирсэн бичиг 2.5 хувь, Тамгын газарт ирсэн бичиг 14.7 хувь, Улсын Их Хурлаас явуулсан бичиг 26.6 хувь, ирсэн өргөдөл, гомдол 16.5 хувиар өссөн байна.

### Албан хэрэг хөтлөлтийн журмыг шинэчлэв.

2020 онд баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журамд нийцүүлж, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг журамлах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 819 дүгээр захирамжаар “Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг шинэчлэн батлав.

Уг журмаар албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын болон бүтцийн нэгжийн удирдлага, ажилтны хүлээх үүрэг тодорхой болсон ба баримт бичгийн төслийг боловсруулах, санал авах, ирсэн баримт бичигтэй танилцах, цохолт хийх, шийдвэрлэлтэд хяналт тавих ажиллагааг албан хэрэг хөтлөлтийн системээр хийх, захиргааны шийдвэр гаргах ажиллагааг хуульд заасан журмын дагуу баримтжуулах харилцааг нарийвчлан зохицуулсан болно.


### Архив

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн баримтыг бүрэн бүрдүүлж, архивт хүлээлгэн өгөх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, дараах баримтаар сан хөмрөгийг баяжууллаа.

Үүнд:

- Цаасан суурьтай 1119 хадгаламжийн нэгж:
  - Байнга хадгалах хадгаламжийн нэгж 694;
  - 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 41;
  - Түр хадгалах хадгаламжийн нэгж 384;
- Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хорооны 2020 оны дүрс бичлэгийн blue-ray disc 189;
- Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой гэрэл зургийн файл 15142.


Цаасан суурьтай хадгаламжийн нэгж:



Архивын бүрдүүлэлтийг 2020 онтой харьцуулбал цаасан суурьтай баримт 54 хадгаламжийн нэгж буюу 4.6 хувь буурсан байна.

Хадгаламжийн нэгжийг хадгалалтын хугацаагаар 2020 онтой харьцуулан үзвэл “Байнга хадгалах” 257 буюу 27 хувиар буурч, “70 жил хадгалах” 8 буюу 24.2 хувь,

“Түр хадгалах” 195 буюу 103 хувиар тус тус өсжээ. Цахим архивын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн хадгаламжийн нэгж 21.3 хувиар буурч, төрийн архивын тоо бүртгэл мэдээллийн AMS программд бүртгэсэн баримтын тоо 172.9 хувиар өссөн байна.



### 7.3. Санхүүгийн удирдлага, дотоод аудит (Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл)

Улсын Их Хурлын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд санхүү, төсвийн удирдлагыг Улсын Их Хурлын тухай болон Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж, төсвийн захирагч, Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлгийг шаардлагатай мэдээ, тайлан, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тооцоо судалгаагаар шуурхай хангаж ажиллалаа.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Улсын Их Хурлын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлын төсөв 61,907.4 сая төгрөгөөр батлагдсан. Төсвийн жилийн хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлэг, Тамгын газар, Нийтлэг ажил үйлчилгээ, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаанд батлагдсан төсвийг хуваарийн дагуу тухай бүр гүйцэтгэлийг ханган ажиллав.

#### Улсын Их Хурлын 2021 оны төсвийн гүйцэтгэл (төсвийн эх үүсвэрээр)

Төсвийн бүлэг	Батлагдсан төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)	Гүйцэтгэл (Хувиар)	Гүйцэтгэлд эзлэх хувь
Урсгал зардлын төсөв	58,337.1	56,939.9	97.6%	94.4
Хөрөнгө оруулалтын төсөв	3,570.3	3,431.7	96.1%	5.6
<b>Нийт дүн</b>	<b>61,907.4</b>	<b>60,371.6</b>	<b>97.5%</b>	<b>100.0</b>



2021 онд нийт батлагдсан төсвийн 59 хувь буюу 36.5 тэрбум төгрөг Улсын Их Хурлын гишүүд, 3.4 хувь буюу 2.1 тэрбум төгрөг Байнгын хороод, 6.7 хувь буюу 4.2 тэрбум төгрөг Улсын Их Хурлын нийтлэг үйл ажиллагаа, 3.5 хувь буюу 2.1 тэрбум төгрөг

Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, 21.3 хувь буюу 13.2 тэрбум төгрөг Тамгын газар, 0.4 хувь буюу 0.2 тэрбум төгрөг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд, 5.8 хувь буюу 3.6 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтад тус тус хуваарилагдсан байна.


### Улсын Их Хурлын 2021 оны төсвийн гүйцэтгэл (төсвийн нэгжээр)

№	Нэгжийн нэр	Батлагдсан төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)	Хэмнэлт, хэтрэлт (сая.төг)	Гүйцэтгэл (Хувиар)	Гүйцэтгэлд эзлэх хувь
А	Б	1	2	3	4	5
1	Улсын Их Хурлын гишүүд	36,524.4	35,099.6	1,424.8	56.7%	59%
2	Байнгын хороод	2,079.0	2,029.0	50.0	3.3%	3.4
3	Улсын Их Хурлын нийтлэг үйл ажиллагаа	4,158.1	4,118.0	40.1	6.7%	6.7%
4	Улсын Их Хурал дахь намын бүлгүүд	2,144.5	2,368.1	-223.5	3.8%	3.5%
5	Улсын Их Хурлын Тамгын газар	12,544.0	12,469.9	74.1	20.1%	21.3%
6	Улсын Их Хурлын даргын ажлын алба	619.6	693.3	-73.7	1.1%	1.1%
7	ТТБЗөвлөл	267.6	162.2	105.5	0.3%	0.4%
8	Хөрөнгө оруулалт	3,570.3	3,431.7	138.6	5.5%	5.8%
<b>ДҮН</b>		<b>61,907.4</b>	<b>60,371.6</b>	<b>1,535.8</b>	<b>97.5%</b>	<b>100.0%</b>

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны төсвийн нийт гүйцэтгэлийн 94.3 хувь буюу 56,939.9 сая төгрөг урсгал зардалд,

5.7 хувь буюу 3,431.7 сая төгрөг хөрөнгийн зардалд зарцуулагдсан байна.

### Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны төсвийн гүйцэтгэл (Төсвийн багц)



Төсвийн зарцуулалтын 56.7 хувь буюу 35.1 тэрбум төгрөг Улсын Их Хурлын гишүүд, 3.3 хувь буюу 2.0 тэрбум төгрөг Байнгын хороод, 3.8 хувь буюу 2.4 тэрбум төгрөг Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, 6.7 хувь буюу 4.1 тэрбум төгрөг Улсын Их Хурлын нийтлэг үйл ажиллагаа, 21.2 хувь буюу 13.2 тэрбум төгрөг Улсын Их Хурлын

Тамгын газар, 0.3 хувь буюу 0.02 тэрбум төгрөг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, 5.5 хувь буюу 3.4 тэрбум төгрөг хөрөнгө оруулалтад зарцуулагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны төсвийн гүйцэтгэл 60.4 тэрбум төгрөг буюу 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

## 2022 оны төсвийн төлөвлөлт

Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны төсөв 68.7 тэрбум төгрөгөөр батлагдав. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль шинээр батлагдаж, 2022 оноос хэрэгжиж эхлэх болсонтой холбоотойгоор Улсын Их Хурлын хяналт шалгалтын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэх хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах төсөв 1,562.8 төгрөг, Ардын Их Хурлын депутат 225 ахмад настанд олгох нэг удаагийн буцалтгүй

тусламж 2,250.0 сая төгрөг, Улсын Бага Хурлын 12 гишүүнд олгох 840.0 сая төгрөг нийт 3,090.0 сая төгрөг, Монгол Улсын ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2021 оны 97 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 300.0 сая төгрөг зэрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлууд нэмэгдэж батлагдав.


## Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны батлагдсан төсөв (Төсвийн захирагчаар)

№	Төсвийн захирагч	2020 оны батлагдсан төсөв	2021 он Төсвийн төсөл	2022 оны хуваарилсан төсөв	Өмнөх оны батлагдсан төсөвтэй харьцуулсан өөрчлөлт
1	Улсын Их Хурлын гишүүд	29,230.5	32,017.0	32,372.9	355.9
2	Байнгын хороод	2,095.0	2,805.0	1,846.0	(959.0)
3	Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг	1,012.0	2,280.5	2,578.9	298.4
4	Улсын Их Хурлын нийтлэг арга хэмжээ	7,028.8	7,505.5	5,601.6	(1,903.9)
5	Тамгын газар	6,722.1	15,897.6	19,856.3	3,958.8
	Улсын Их Хурлын даргын ажлын алба	522.7	862.6	682.0	(180.6)
6	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл	273.0	539.0	187.1	(351.9)
<b>НИЙТ ДҮН</b>		<b>46,884.1</b>	<b>61,907.1</b>	<b>63,124.8</b>	<b>1,217.7</b>

## Дотоод аудит, эрсдэлийн удирдлага


Тамгын газрын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын чиглэлээр 2021 онд 23 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж, оны эцэст 26 аудитын ажлыг гүйцэтгэв. Гүйцэтгэсэн аудитыг ангилж үзвэл гүйцэтгэлийн 18, санхүүгийн 2, нийцлийн 4, санхүүгийн 2 хяналт шалгалт хийгдсэн байна.

Тамгын газрын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар тэдгээрийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлтэй хүчин зүйлийг илрүүлэн тогтоож, энэхүү эрсдэлийг бууруулах, эрсдэлийн эсрэг арга хэмжээ авах талаар холбогдох нэгжүүдэд 244 заалт бүхий зөвлөмж өгч ажиллав.



Дээр дурдсан зөвлөмжийн 7 хувь нь чиг үүргийн, 11 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, 7 хувь нь санхүүгийн бүртгэл, тайлагналтын ажлыг сайжруулах, 9 хувь нь үүрэг, даалгаврын хэрэгжилтийг сайжруулах, 7 хувь нь төлөвлөлт, тайлагналтын үйл ажиллагаатай холбоотой, 2 хувь нь

хүний нөөцтэй холбоотой, 16 хувь нь үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой, 14 хувь нь эрсдэлийн удирдлагыг сайжруулах, 18 хувь нь дотоод хяналт, хариуцлагын асуудал, 9 хувь нь аудитын зөвлөмжийн биелэлтийг сайжруулах асуудалд чиглэгдсэн байна.



## **Эрсдэлийн удирдлагын хороо байгуулав.**

Тамгын газрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоонд анх удаа дотоод аудит хийж, Дотоод аудитын Олон улсын институтээс баталсан Олон улсын стандарт, холбогдох арга зүй, аргачлалын дагуу засаглалын төлөвшлийг 7 хүрээний 21 шалгуур үзүүлэлтээр, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг 3 хүрээний 9 харгалзах үзүүлэлтээр, дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийг дотоод хяналтын 5 бүрэлдэхүүн, тэдгээрийн 17 шалгуур үзүүлэлтээр харьцуулан шинжилж, дүгнэлт, зөвлөмж гаргав.

Энэ нь Тамгын газрын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулахад бодит дэмжлэг үзүүлсэн, үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга дотоод аудитын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Тамгын газрын

бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн 6 захирамж гаргаж, хугацаатай үүрэг, даалгавар өгч ажилласан нь дотоод аудитын зөвлөмжийг ашиглах, хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл, дадлыг төлөвшүүлэх, зөвлөмжийн биелэлтийг эргэн хянах үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн шинэлэг, үр дүнтэй арга хэмжээ болов.

Түүнчлэн Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 458 дугаар захирамжаар Тамгын газрын Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг баталж, Эрсдэлийн удирдлагын хороог байгуулав.

Ингэснээр Тамгын газрын эрсдэлийг удирдах үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянах механизм бүрдлээ.

### 5.3. Дүгнэлт, зорилт

#### Дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дотоод эрх зүйн орчин, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах талаар 2020 онд тавьсан зорилтоо бүрэн хэрэгжүүллээ.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 19 дүрэм, журмыг шинэчлэн батлагдсан хууль, тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулан батлуулж, Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэв.

Хууль тогтоомжийн төслийг боловсруулах, батлуулах, хүргүүлэх, чуулганы хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэхтэй холбоотой 5 журмыг шинэчилснээр Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиг үүргийн хэрэгжилт

сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлж байна.

“Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан нь хувь хүний болон гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх бодлогын алхам болов.

Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгын хүрээнд 1,306.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар албан хаагчдын компьютер, техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, өрөө тасалгааг засан сайжруулж, ая тухтай орчин нөхцөлд, бүтээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.

Тамгын газрын Ёс зүйн зөвлөл болон Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, үйл ажиллагааны журмыг тогтоосноор албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, Тамгын газрын засаглал, эрсдэлийг удирдах, хянах үр нөлөө бүхий нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх эхлэлийг тавив.

## ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГАТАЙ ПАРЛАМЕНТЫН МЭРГЭШСЭН АЖЛЫН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ.

1. Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн орчны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.
  - 1.1. Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын шинэчлэлийг бүрэн хийж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
  - 1.2. Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилж, мөрдөнө.
2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын гүйцэтгэлийг цахимаар хянах механизм нэвтрүүлнэ.
  - 2.1. Улсын Их Хурлын болон Тамгын газрын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн үр дүн, ололтыг нэгтгэн дүгнэж, 2025 он хүртэл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батална.
  - 2.2. Тамгын газрын бүтцийн нэгж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах, үнэлэх ажиллагааг цахимаар явуулж хэвшинэ.
3. Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.
  - 3.1. Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, техник, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.
  - 3.2. Тамгын газрын албан хаагчдын Ёс зүйн сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
4. Тамгын газрын ажилтнуудын ажлын бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын цогц бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  - 4.1. Улсын Их Хурлын гишүүд, гадаад орнуудын парламентын гишүүдтэй мэдээлэл солилцох, харилцан туршлага судлах уулзалт хийх, гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдтэй тодорхой асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон талт ажлыг тогтмолжуулна.
  - 4.2. Тамгын газрын албан хаагчдыг хуулийн төсөл боловсруулагчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
  - 4.3. Тамгын газрын ажилтнуудыг оролцуулсан хүний нөөцийн цогц чадамжийн үнэлгээ хийж, үр дүнд тулгуурлан албан хаагчдыг чадавхжуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Санхүү, хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.
  - 5.1. Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, байгууллагын дотоод системтэй интеграц хийж ажиллах боломжийг бүрдүүлнэ.
  - 5.2. Хөрөнгийн бүртгэлийг хялбаршуулан автоматжуулах хүрээнд QR кодын систем нэвтрүүлж, гар утасны аппликэйшн ашиглан тооллого хийдэг болно.
  - 5.3. Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехийн үйлчилгээнд цахим шилжилтийг эхлүүлж, чанарын хяналтын тогтолцоо нэвтрүүлнэ.

# НЭГДСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ-2021

Улсын Их Хурлын Тамгын газар 2021 онд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах

нөхцөлөөр хангах хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, ажиллав. 2021 онд бид гүйцэтгэлийн 51 зорилтын хүрээнд 299 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүллээ.

## ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



2021 онд Тамгын газар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, төслийн бүрдүүлбэрийг хангах, хэлэлцүүлэн батлуулах бүх үе шатанд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг зохион байгуулах техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах хуульд заасан чиг үүргээ үр дүнтэй, бүтээмжтэй хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэж байна.

Үүнийг илтгэх нэг үзүүлэлт бол өмнөх онтой харьцуулахад парламентаас баталсан хууль тогтоомж 72,2 хувь, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 18 хувь, Байнгын, дэд, түр хороодын хуралдаан 17.7 хувиар тус тус өссөн дүн юм.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хууль тогтоомжийг боловсруулан батлуулах зорилтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хууль, Монгол Улсын Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ыг Улсын Их Хурлаас боловсруулах, хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Улсын Их Хурлаас 2021 оны байдлаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн батлуулах хуваарьт заасан хууль тогтоомжийн 45 хувийг батлаад байна.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан Хууль зүйн дүгнэлт гаргах журмыг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийн төслийн талаарх хууль зүйн дүгнэлт, лавлагаа, зөвлөмж тус бүр 1-ийг боловсруулж, холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр хуулийн төсөл Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх, хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байх зарчмыг хангах, Улсын Их Хурлын хууль тогтоох ажлын чанар сайжрахад бодит дэмжлэг болов.

Албан хаагчдыг коронавируст цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, вакцинжуулалтад хамруулах арга хэмжээг шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэв.

Зохион байгуулалтын бэлтгэлийг өндөр түвшинд хангасны үндсэн дээр Ардын хувьсгалын 100 жилийн ой болон Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 110 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг цахимаар болон танхимаар нэгэн зэрэг зохион байгуулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үнэ цэнэ,

Монгол бахархлыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмэр оруулав.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан даргалагчид зориулсан хуулийн төсөл хэлэлцэн батлах үе шатыг хялбаршуулсан байдлаар тайлбарласан гарын авлага боловсруулж, “Хэлэлцэх асуудлын бүрдлийн хавтас”-ыг хэрэглэж хэвшүүлснээр хуралдааныг хуульд заасан журмын дагуу саатал, зөрчилгүй удирдан явуулах боломжийг бүрдүүллээ.

2022 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүн шинжилгээ хийх ажлыг өргөжүүлж, Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэх, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоход арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг сайжруулахаар төлөвлөж байна.

## ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлахад шаардлагатай харьцуулсан судалгаа, лавлагааг бүрэн багтаасан “Хуулийн төслийн мэдээлэл, лавлагааны иж бүрдэл”-ээр Улсын Их Хурлын гишүүдийг хангаж, хэлэлцүүлгийн явцад 11 удаа багц мэдээлэл бэлтгэн, холбогдох ажлын хэсэгт зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажилласан нь парламентын хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна.

Уг хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Тамгын газраас 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмуудыг боловсруулж, батлуулах, хүний нөөцийн чадавхыг сайжруулах ажлыг төлөвлөн, хэрэгжүүлж байна.

2021 онд Улсын Их Хурал, Байнгын, дэд хорооны тогтоол, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй

танилцах, хэрэгжилтийг хянан шалгах үүрэг бүхий 37 ажлын хэсэг (2 түр хороо)-т давхардсан тоогоор Улсын Их Хурлын 256 гишүүн ажиллахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа. 2020 онтой харьцуулахад ажлын хэсгийн тоо 51.4 хувиар, гишүүдийн тоо 59.8 хувиар нэмэгдсэн байна.

Улсын төсвийн тухай хууль тогтоомжийн төсөл төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэхийг өмнөх онуудын төсөв, төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, танилцуулга, холбогдох судалгаа, саналыг Төсвийн байнгын хороонд хүргүүлж ажиллав.

Мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэл, 2021 оны 1-11 дүгээр сарын гүйцэтгэлд тухай бүр дүн шинжилгээ хийж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр боловсруулан Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажиллав.



## УЛСЫН ИХ ХУРАЛ, ТАМГЫН ГАЗРЫН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ



“Цахим парламент” болох зорилтын хүрээнд Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны цахим шилжилтийг дэмжих дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн гурван цогц шинэчлэл хийв.

Энэ хүрээнд Тамгын газрын серверийг 14 жилийн дараа шинэчилж, олон улсын стандартад нийцсэн аюулгүй байдлын хяналтын системийг суурилууллаа. Мөн хуралдааныг шууд дамжуулах интернэт телевизийн iptv.parliament.mn-ийг шинээр нэвтрүүлж, үйлчилгээний тасалдалгүй, найдвартай байдлыг хангасан интернэтийн нөөц урсгал бий болгов.

Үүний үр дүнд сервер, интернэтийн үйлчилгээний найдвартай байдал хангагдаж, Улсын Их Хурлын гишүүдэд цаг үеийн мэдээлэл, судалгааны тойм, нэвтрүүлэг, дүрст мэдээллийг шуурхай хүргэх боломж нэмэгдлээ.

2021 онд хуулийн төсөлд санал авах, хэлэлцүүлэх “lawforum.parliament.mn” системд нийт 59 хууль тогтоомжийн

төслийг байршуулснаар иргэд, олон нийт давхардсан тоогоор 98.098 удаа хууль тогтоомжийн төсөлтэй танилцаж, 1222 санал ирүүлсэн нь цахим систем ашиглан хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чухал алхам болов.

Тамгын газраас 2020 онд үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн Байгууллагын нөөцийн удирдлагын ERP системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээ авсны үр дүнд ажлын цаг ашиглалт, албан хэрэг хөтлөлт, түүнд тавих хяналт бүрэн цахимжлаа.

Тус системд тулгуурлан файлын нэгдсэн сан (cloud.parliament.mn) бий болгож, архивын материалтай цахимаар танилцах боломж бүрдсэнээр мэдээлэл солилцох, дамжуулах, хамтран ашиглах мэдээллийн нэгдсэн тогтолцоо бий болж, ажлын бүтээмж, уялдаа холбоо сайжирч байна.

## ТӨЛӨӨЛЛИЙН ЧИГ ҮҮРЭГ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ



Улсын Их Хурал, түүний Тамгын газрын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдээлэх, сурталчлах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрүүдийн төсөлд олон нийтийн саналыг авах, хууль, бусад шийдвэрийг тайлбарлан таниулах чиглэлээр нийт 49 арга хэмжээг

хэрэгжүүлж, Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсгийн 167 удаагийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол, хурал, уулзалтыг зохион байгуулахад зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллажээ.

Тухайлбал, Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас

санал болгосон нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлох, зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, сонсголд оролцогч, сонсголд даргалагчийн эрх хэмжээ, сонсголыг зохион байгуулах, сонсголын тайлан гаргах асуудлыг нарийвчлан зохицуулсан “Монгол Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам”-ыг Улсын Их Хурлаас батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэв.

Уг журмын дагуу Авлигатай тэмцэх газрын дэд дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчдийн томилгооны сонсголыг зохион байгуулснаар Улсын Их Хурлаас томилогдох албан тушаалтныг нээлттэй сонсгол явуулсны үндсэн дээр томилох үйл ажиллагаа албан ёсны тогтолцоо болж, түүнийг хэрэгжүүлж ажиллах Тамгын газрын чадавх сайжирч байна.

Батлагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн дэх Улсын Их Хурлын албан ёсны цахим хаягуудаар дамжуулан хүртээмжтэй, тасралтгүй, шуурхай хүргэж ажилласны дүнд олон нийтийн цахим сүлжээн дэх хэрэглэгчдийн тоо 2020 онтой харьцуулахад 4.3-аас 36.4 хувиар өсчээ.

Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн

хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулсан “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой” маркийг хэвлүүлж, “Байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 30 жилийн ой” сэдэвт маркийн анхны өдрийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Түүхэн ойд зориулсан эдгээр маркууд нь олон улсад манай парламентын ардчиллын түүх, хөгжлийг таниулан сурталчлах шинэлэг, бодитой алхам болов.

2021 онд Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газраас “Парламентын боловсрол” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхэллээ. Ингэснээр парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх шинэ механизм бүрдэж, edu.parliament.mn цахим хуудас, Парламентын боловсролын сургалтын хөтөлбөр, гарын авлагатай болов.

“Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг анх удаа зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн 9-11 дүгээр ангийн 90 сурагчийг хамруулан ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох үйл ажиллагааны талаарх ойлголт өгч, шийдвэр гаргах түвшинд бодитой оролцох боломжийг нь дэмжлээ.

Ингэснээр Монгол Улсын парламент дэлхийн бусад улс орны парламентуудын нэгэн адил өсвөр үе, залуучуудад зориулсан сургалтын тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлдэг шинэ жишиг тогтох эхлэлийг тавив.

## ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ



Тамгын газар 2021 онд Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдийн захиалга болон цаг үеийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 81 судалгааны ажил эрхлэн гүйцэтгэж, Улсын Их Хурлаас хууль тогтоох

бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь судалгаа шинжилгээ, лавлагаа, мэдээллээр шуурхай хангаж ажиллалаа. Судалгааны ажлын тоо өмнөх оноос 40 хувиар өссөн байна.

Эдгээрээс цахим засаглал, тоон гарын үсгийн эрх зүйн зохицуулалт, олон улсын чиг хандлага, кибер аюулгүй байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага, нийтийн мэдээллийн ил тод байдал болон хүний хувийн мэдээлэл хамгаалах талаарх бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалт зэрэг сэдвээр 7 төрлийн судалгаа хийж, Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийг мэдээллээр хангаж ажилласнаар Монгол Улсад цахим хөгжлийн эрх зүйн орчныг цогцоор бий болгоход томоохон дэмжлэг болсон гэж үзэж байна.

“Парламентын судалгаа шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл, “Парламент” судалгааны эмхэтгэлийн 4 боть, “Мэдээлэл судалгаа” аналитик тойм мэдээллийн 25 цуврал эрхлэн гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийг шинжлэх ухаанд суурилсан судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангаж, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллав.

2021 онд дэвшүүлсэн зорилтынхоо дагуу “Парламентын сургалт”-ын 15 дэд хөтөлбөр, тэдгээрийн агуулгыг боловсруулж, “Сургалтын цахим систем” бий болгосноор нь Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмж, чанарыг дээшлүүлж, сонгон суралцах боломж өргөжив.

Улсын Их Хурлын гишүүд болон Тамгын газрын албан хаагчдад зориулсан нийт 48 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор 2200 албан хаагчийг хамруулан, Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилтоо хэрэгжүүлж ажиллалаа.

Номын санг цахимжуулах системийн шинэчлэл, хөгжүүлэлтийн ажил эхэлж, Номын баярыг бусад байгууллагатай хамтран зохион байгуулж хэвшсэн нь иргэдэд ном унших дадал, соёлыг түгээх үр дүнтэй алхам боллоо.

Парламентын судалгааны хүрээлэнгийн хэрэглэгчийн үнэлгээний судалгааг Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн Ажлын алба, Тамгын газрын ажилтнуудыг оролцуулан анх удаа гүйцэтгэж, цаашид үйлчилгээний чанар, хүртээмж, судалгаа шинжилгээний бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх арга зам, баримтлах чиглэлээ тодорхойллоо.

Парламентын судалгааны хүрээлэнгийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн сан, Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн, ХБНГУ-ын Фридрих Эбертийн сантай хамтран Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын албан хаагчдад зориулсан хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулав.

## ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг коронавируст цар тахлын үеийн нөхцөл байдалд зохицуулан зохион байгуулснаар олон улс, бүс нутгийн байгууллагуудын ээлжит хурал, чуулган, хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын дарга, гишүүд, Тамгын газрын удирдлага биечлэн болон цахимаар оролцож, олон тал

хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлж чадлаа.

Дэлхийн улс орнуудын парламентын төлөөлөгчидтэй хоёр талын уулзалтуудыг амжилттай зохион байгуулсан нь хууль тогтоох байгууллагууд хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, уламжлалт найрсаг

харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд чухал алхам болов.

Улсын Их Хурлын даргын АНУ, БНЭУ-д, дэд даргын БНПУ-д хийсэн айлчлал, ОХУ, БНПУ, БНИУ, БНФУ-ын парламентын төлөөлөгчдийн Монгол Улсад айлчилсан айлчлал, БНХАУ, ОХУ-ын парламентын удирдлага, Байнгын хороодын дарганарын дээд хэмжээний цахим уулзалтуудыг зохион байгуулав.

Улсын Их Хурал дахь парламентын бүлгэмийн дарга, гишүүд өөрсдийн санаачилгаар дэлхийн улс орнуудын парламентын гишүүд, Элчин сайд нартай биечлэн болон цахимаар уулзаж, хоёр улсын харилцааны өнөөгийн тулгамдсан болон цаг үеийн бусад асуудлаар ярилцаж, тодорхой санал, санаачилга дэвшүүлж ажиллалаа.

## ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГА



Монгол Улсын Их Хурлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дотоод эрх зүйн орчин, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах талаар 2020 онд тавьсан зорилтоо бүрэн хэрэгжүүллээ.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 19 дүрэм, журмыг шинэчлэн батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулан батлуулж, Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэв.

Хууль тогтоомжийн төслийг боловсруулах, батлуулах, хүргүүлэх, чуулганы хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангах, хууль тогтоомжийн хувийн хэрэг бүрдүүлэхтэй холбоотой 5 журмыг шинэчилснээр Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх чиг үүргийн хэрэгжилт

сайжирч, ажлын бүтээмж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлж байна.

“Улсын Их Хурлын Тамгын газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан нь хувь хүний болон гэр бүлийн хөгжлийг дэмжих, эрүүл мэндийг хамгаалах замаар тогтвортой, бүтээмжтэй ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх бодлогын алхам болов.

Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгын хүрээнд 1,306.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар албан хаагчдын компьютер, техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, өрөө тасалгааг засан сайжруулж, ая тухтай орчин нөхцөлд, бүтээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.

Тамгын газрын Ёс зүйн зөвлөл болон Эрсдэлийн удирдлагын хороог байгуулж, үйл ажиллагааны журмыг тогтоосноор албан хаагчдын ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, Тамгын газрын засаглал, эрсдэлийг удирдах, хянах үр нөлөө бүхий нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх эхлэлийг тавив.

# ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ЗОРИЛТ

## ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ.

1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүн шинжилгээ хийх ажлыг өргөжүүлж, хуулийн төсөл хэлэлцүүлэх цахим системийн хэрэглээг шинэ шатанд гаргана.
  - 1.1. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд олон улсын жишиг аргачлалаар “Хууль зүйн дүгнэлт гаргах” ажлыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, хэвшүүлнэ.
  - 1.2. Хуулийн төсөл хэлэлцүүлэх болон иргэдийн санал, хүсэлт авах цахим системийн ашиглалт, хэрэглээг хэвшүүлж, хууль тогтоох үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоог идэвхжүүлнэ.
2. Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлэхэд арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.
  - 2.1. Хүний эрхийн мэдрэмжтэй хууль тогтоох үйл ажиллагааг төлөвшүүлж, хуулийн төсөл хүний эрхийг хангасан эсэхэд үнэлгээ хийх аргачлалыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ.
  - 2.2. Хууль тогтоомжийн төсөл жендэрийн мэдрэмжтэй эсэхийг шалгуураар үнэлэх үнэлгээний аргачлалыг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.
3. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлж, хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг сайжруулна.
  - 3.1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.
  - 3.2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэлийн загвар, бүтцийг орчин үеийн парламентын жишигт нийцүүлж шинэчилнэ.

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЭЭМЖ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ.

1. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, албан хаагчдыг чадавхжуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулна.
  - 1.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хялбаршуулсан гарын авлага, танилцуулгыг боловсруулж, Улсын Их Хурлын гишүүд болон хянан шалгах үйл ажиллагаанд оролцогчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангана.
  - 1.2. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлэх арга зүй, зохион байгуулалтын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн сургалт, чадавхжуулах үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлнэ.
2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан журмуудыг баталж, мэдээллийн нэгдсэн сантай болно.
  - 2.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан “Улсын Их Хурлаас хэрэгжүүлэх хянан шалгах ажлыг зохион байгуулах” болон холбогдох бусад журмыг баталж, мөрдөнө.

- 2.2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг дүгнэх, хяналт шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг агуулсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан бий болгож, ажиллах журмыг тогтооно.
- 2.3. Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх Тамгын газрын чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, холбогдох нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулна.
3. Парламентын хянан шалгах үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
  - 3.1. Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг төрийн зарим байгууллагыг түшиглэн явуулах, тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулах ажлыг эхлүүлж, эрх зүйн зохицуулалт бий болгоно.
  - 3.2. Шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн, бодитой мэдээллээр хууль тогтоогчдыг хангах зорилгоор хуулийн төслийн зардал, үр нөлөөний тооцоолол, зардал бууруулах санал, дүгнэлт зэрэг мэдээллээр Улсын Их Хурлын гишүүдийг хангаж ажиллана.
  - 3.3. Богино, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, төсвийн төсөлд шинжилгээ хийх аргачлалыг шинээр боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

### **УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦАХИМ ШИЛЖИЛТ, ИННОВАЦ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, ПАРЛАМЕНТЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ҮР ДҮНД ХҮРГЭХ.**

1. Цахим парламент, инновацийн тогтолцоо бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.
  - 1.1. Цахим парламент, инновацийн бодлого хариуцсан нэгж байгуулж, олон улсын сайн жишигт тулгуурлан үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.
  - 1.2. Улсын Их Хурал, Тамгын газрын мэдээлэл солилцох нэгдсэн системийн эхлэлийг тавьж, албан хаагчдын мэдээлэл, өгөгдлийн дүн шинжилгээний чадавхыг сайжруулна.
  - 1.3. Иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг цахимаар авдаг “E-petition” цогц системийг олон улсын жишиг аргачлалын дагуу үйл ажиллагаандаа нэвтрүүлж, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
2. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны цахим системийн шинэчлэлийг эхлүүлнэ.
  - 2.1. Нэгдсэн хуралдааны танхимын ирцийн бүртгэл, санал хураалтын системийг цахим хуралдааны программ хангамжийн хамт бүрэн шинэчилнэ.
  - 2.2. Цахим хуралдааны арга зүйг шинэчилж, биечлэн болон цахим оролцооны ялгааг арилгах, нэгдсэн тайлан гаргах боломж бүрдүүлнэ.
3. “D парламент” аппликэйшнийг нэвтрүүлж, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг шуурхай, хялбар аргаар олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлнэ.
  - 3.1. Иргэд, олон нийтэд парламентын үйл ажиллагааг сурталчлан таниулах, үйл ажиллагааны хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “D парламент” аппликэйшнийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.

- 3.2. “lawforum.parliament.mn” системийн хэрэглэгчдийн үнэлгээний судалгаанд үндэслэн системийн ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийн төслийн мэдээллийг хэрэглэгчдэд хялбар, хүртээмжтэй хүргэх арга хэлбэрийг тодорхойлж, хэрэгжүүлнэ.
4. Тамгын газрын үйл ажиллагааны дотоод цахим системийн хэрэглээг хэвшүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгыг үр дүнд хүргэнэ.
  - 4.1. Байгууллагын нөөцийн удирдлагын систем (ERP)-д тулгуурлан албан хэрэг хөтлөлт, өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлт, төлөвлөгөө, тайлан, албан бичгийн боловсруулалтыг бүрэн цахимжуулна.
  - 4.2. Тамгын газрын үйл ажиллагаанд ашиглаж буй цахим системүүдийн ашиглалт, хэрэглээнд дүн шинжилгээ хийж, цаасны хэрэглээг 30 хүртэл хувиар бууруулна.
  - 4.3. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсгийн тогтолцоо нэвтрүүлж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээ авна.

## **НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ИРГЭДИЙН ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ.**

1. Парламентын нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
  - 1.1. “Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв”-үүдийг орон нутагт байгуулах оновчтой шийдлийг боловсруулж, шийдвэрлүүлнэ.
  - 1.2. Улсын Их Хурлын дэргэд Парламентын музей, Парламентын сургалтын танхим байгуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.
2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг мэргэжлийн өндөр түвшинд оновчтой зохион байгуулж, хэрэгжүүлнэ.
  - 2.1. Дүрст болон нийгмийн сүлжээний контентийн форматыг сайжруулж, аудио болон видео подкастаар мэдээлэл хүргэх ажлыг шинээр эхлүүлнэ.
  - 2.2. “www.parliament.mn” цахим хуудсыг дэлхийн парламентуудын жишигт нийцүүлэн шинэчилнэ.
  - 2.3. Улсын Их Хурлын танилцуулгыг монгол, англи хэл дээр шинэчлэн хэвлүүлж, шинэлэг агуулгаар баяжуулна.
3. Улсын Их Хурлын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны бодлогыг тодорхойлж, техникийн шинэчлэлийг эхлүүлж, албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлнэ.
  - 3.1. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, техникийн шинэчлэлийг эхлүүлнэ.
  - 3.2. Хэлтсийн үйл ажиллагаанд дэлхийн улс орнуудын парламентын туршлагыг нэвтрүүлж, энэ зорилгоор албан хаагчдыг сургалтад хамруулна.
  - 3.3. “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийг монгол бичгээр бэлтгэхэд шаардлагатай хөрвүүлгийн программ эзэмшиж, “Хуралдай” фонтыг хэрэглээнд нэвтрүүлэн, сайтын мэдээллийн 10-15 хувийг монгол бичигт шилжүүлнэ.

## **ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ.**

1. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг Олон Улсын Парламентын Холбоо болон ижил түвшний байгууллагуудтай өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
  - 1.1. Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийн зорилтыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
  - 1.2. Олон Улсын Парламентын Холбоо, түүний дэргэдэх Хүний эрх, жендэрийн хөтөлбөр болон Инновацийн төвтэй шинэ хамтын ажиллагааг эхлүүлнэ.
  - 1.3. Улсын Их Хурлын Тамгын газраас гадаад орнуудын парламентын Тамгын газартай тогтоосон найрсаг харилцааг идэвхжүүлэн хөгжүүлж, хамтын ажиллагааны шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  - 1.4. Тамгын газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлийг тэргүүлэх зорилт болгон Тамгын газрын албан хаагчдыг гадаад улсад туршлага судлах, дадлагажих хөтөлбөрт хамруулах, олон улс, бүс нутгийн хурал, семинарт оролцуулахад дэмжлэг үзүүлнэ.

## **ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ.**

1. “Парламентын боловсрол” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлнэ.
  - 1.1. “Парламентын боловсрол” хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн боловсролын төвүүдээр дамжуулан хэрэгжүүлж, иргэддээ ардчилал, хүний эрх, Үндсэн хуульт болон парламентат ёсны мэдлэг, боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.
  - 1.2. Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан “Өсвөрийн парламент” үндэсний арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
  - 1.3. Оюутан залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан Парламентын боловсролын гарын авлага боловсруулан, залуучуудын дунд парламентын мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулж, Үндсэн хуульт болон парламентат ёсны мэдлэг олгох ажлыг эрчимжүүлнэ.

## **ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА, ЛАВЛАГААГААР ХАНГАХ.**

1. Баримт нотолгоонд суурилсан мэдээлэл, судалгаагаар Улсын Их Хурлын гишүүдийг тогтмол, шуурхай хангаж, Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомжийн чанар, үндэслэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
  - 1.1. Бодлогын судалгааны мэдээллийн нэгдсэн сан бий болгох зорилгоор Монгол Улсад бодлого судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг судалгааны байгууллагууд, номын сангууд болон төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох цахим сүлжээний эхлэлийг тавьж, портал системийн хөгжүүлэлтийг эхлүүлнэ.
  - 1.2. Парламентын судалгааны хүрээлэнгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ хэрэгжүүлнэ.



- 1.3. Судалгааны цахим сан, хайлтын системийг хөгжүүлж, цахим уншлага хийх боломжийг бүрдүүлэн хэрэглэгчид судалгааны бүтээгдэхүүнтэй хялбар, түргэн шуурхай танилцах нөхцөлийг хангана.
2. Цахим эх сурвалжийг нэмэгдүүлж, Парламентын номын сангийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ.
  - 2.1. Парламентын номын сангийн бүртгэлийг шинэчилж, номын лавлагааг цахим хэлбэрээр шуурхай авах нөхцөл бүрдүүлнэ.
  - 2.2. Номын сангийн фондод байгаа үнэ цэнэтэй ховор ном, сониныг цахим хэлбэрт шилжүүлж, судалгаа шинжилгээний эргэлтэд оруулна.

## **ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГАТАЙ ПАРЛАМЕНТЫН МЭРГЭШСЭН АЖЛЫН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ.**

1. Тамгын газрын үйл ажиллагааны эрх зүйн орчны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.
  - 1.1. Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын шинэчлэлийг бүрэн хийж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
  - 1.2. Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилж, мөрдөнө.
2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын гүйцэтгэлийг цахимаар хянах механизм нэвтрүүлнэ.
  - 2.1. Улсын Их Хурлын болон Тамгын газрын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн үр дүн, ололтыг нэгтгэн дүгнэж, 2025 он хүртэл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батална.
  - 2.2. Тамгын газрын бүтцийн нэгж, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах, үнэлэх ажиллагааг цахимаар явуулж хэвшинэ.
3. Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.
  - 3.1. Тамгын газрын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, техник, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.
  - 3.2. Тамгын газрын албан хаагчдын Ёс зүйн сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
4. Тамгын газрын ажилтнуудын ажлын бүтээмж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын цогц бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  - 4.1. Улсын Их Хурлын гишүүд, гадаад орнуудын парламентын гишүүдтэй мэдээлэл солилцох, харилцан туршлага судлах уулзалт хийх, гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүдтэй тодорхой асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг олон талт ажлыг тогтмолжуулна.
  - 4.2. Тамгын газрын албан хаагчдыг хуулийн төсөл боловсруулагчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
  - 4.3. Тамгын газрын ажилтнуудыг оролцуулсан хүний нөөцийн цогц чадамжийн үнэлгээ хийж, үр дүнд тулгуурлан албан хаагчдыг чадавхжуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5. Санхүү, хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.
  - 5.1. Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд цахим систем нэвтрүүлж, байгууллагын дотоод системтэй интеграц хийж ажиллах боломжийг бүрдүүлнэ.
  - 5.2. Хөрөнгийн бүртгэлийг хялбаршуулан автоматжуулах хүрээнд QR кодын систем нэвтрүүлж, гар утасны аппликэйшн ашиглан тооллого хийдэг болно.
  - 5.3. Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехийн үйлчилгээнд цахим шилжилтийг эхлүүлж, чанарын хяналтын тогтолцоо нэвтрүүлнэ.



